



**Оюу Толгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

**АГУУЛГА**

<b>1. ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>4</b>
1.1. БАРИМТ БИЧГИЙН ДУГААР .....	4
1.2. ЗОРИЛГО .....	4
1.3. ХЭРЭГЛЭЭ .....	4
1.4. ЭХЛЭХ ОГНОО.....	5
1.5. ЭРХ МЭДЭЛ БА УДИРДЛАГА .....	5
<b>2. ХАМРАХ ХҮРЭЭ.....</b>	<b>6</b>
2.1. Удирдлагын төлөвлөгөөний ХАМРАХ ХҮРЭЭ .....	6
2.2. БУСАД УДИРДЛАГЫН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ДАВХЦАХ БАЙДАЛ .....	7
<b>3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....</b>	<b>8</b>
3.1. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ГОЛ ХАРИУЦАГЧИД, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ .....	8
3.2. ГОЛ УЯЛДАА ХОЛБОО.....	9
<b>4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД .....</b>	<b>10</b>
4.1. Монгол улсын холбогдох хууль ТОГТООМЖ .....	10
4.2. Монгол улсын холбогдох СТАНДАРТУУД .....	11
4.3. БОНБНҮ-ий шаардлагууд.....	11
4.4. Монгол улсын ЗАСГИЙН ГАЗРЫН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН БУСАД ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА ШААРДЛАГУУД.....	12
4.4.1. Хөрөнгө оруулалтын гэрээ.....	12
4.5. Олон улсын холбогдох СТАНДАРТ БОЛОН УДИРДАМЖУУД.....	13
4.6. Рио Тинтогийн холбогдох СТАНДАРТУУД.....	13
<b>5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ.....</b>	<b>14</b>
<b>6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ .....</b>	<b>26</b>
6.1. Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэл.....	26
<b>7. МОНИТОРИНГ .....</b>	<b>26</b>
7.1. Мониторингийн шаардлагуудын тойм.....	26
7.2. Гүйцэтгэлийн ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД .....	26
7.3. Мониторингийн ГОЛ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	28
7.3.1. Биологийн олон янз байдлын мониторингийн гол хөтөлбөр.....	28
7.3.2. Гидрологийн тодорхойгүй байдлыг тооцоолох мониторинг .....	30
7.3.3. Ашиглалтын үеийн биологийн олон янз байдлын сөрөг нөлөөллийг бууруулах гол арга хэмжээнүүдтэй холбоотой мониторинг ба БОНБНҮ-гээр батлагдсан ургамал, амьтны мониторингийн хөтөлбөрүүд .....	31
<b>8. СУРГАЛТ.....</b>	<b>41</b>
8.1. Тойм.....	41
8.2. Танилцуулга болон ДАВТАН СУРГАЛТ.....	41
8.3. Ажлын БАЙРАН ДАХ СУРГАЛТ .....	41
<b>9. АУДИТ БА ТАЙЛАН.....</b>	<b>42</b>
9.1. Дотоод аудит .....	42
9.2. Гадаад аудит .....	42
9.3. Бүртгэл хөтлөлт.....	42
<b>10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ .....</b>	<b>43</b>

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

**ХҮСНЭГТҮҮД**

Хүснэгт 1: Гол хариуцагчид болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг .....	8
Хүснэгт 2: Удирдлагын гол хяналтууд .....	16
Хүснэгт 3: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд .....	26
Хүснэгт 4: Мониторингийн гол хэмжилтүүд .....	32

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

## 1. ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Баримт бичгийн дугаар

Энэхүү баримт бичиг нь Оюу Толгой төслийн Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө юм. Тус удирдлагын төлөвлөгөөний лавлагааны дугаар нь ОТ-10-E9-PLN-1001.

### 1.2. Зорилго

Энэхүү удирдлагын төлөвлөгөөний зорилго нь:

- удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, удирдлагын холбогдох нэгжүүдийн уялдаа холбоог харуулах;
- ажлын байрны үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн холбогдох стандартууд, удирдамжуудыг тоймлон гаргах;
- энэ удирдлагын төлөвлөгөөнд хамааралтай төслийн үүрэг хариуцлага, ашиглалтын үе шатны журмууд ба удирдамж заавруудыг тодорхойлох;
- гүйцэтгэлийн Гол Үзүүлэлт (ГҮҮ)-ийг багтаасан мониторингийн болон тайлагналтын журмыг тодорхойлох;
- сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох ба
- дагалдах материалууд ба мэдээллийн лавлагаагаар хангах зэрэг болно.

### 1.3. Хэрэглээ

Энэ удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагууд нь Оюу Толгой компанийн болон гэрээт компаниудын бүхий л үйл ажиллагаанд хамааралтай болно.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2008 он нийтлэгдсэн Рио Тинтогийн биологийн олон янз байдлын бодлого болон 2012 онд гарсан (Хавсралт А) Оюу Толгойн биологийн олон янз байдлын бодлогын дагуу боловсруулсан. Оюу Толгойн биологийн олон янз байдлын зорилтыг Биологийн олон янз байдлын бодлогодоо доорх байдлаар тунхагласан байдаг. Үүнд:

*Өмнийн говийн бүс нутагт хэрэгжиж буй Оюу Толгой төсөл нь эцсийн дүндээ тухайн бүс нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна. Рио Тинто корпорацийн Биологийн олон янз байдлын талаар баримтлах стратегитэй нийцүүлэн, Оюу Толгой нь Өмнийн говийн бүсийн биологийн олон янз байдалд Эерэг Нөлөөлөл Ахиу үзүүлэх зорилго дэвшүүлсэн. Оюу Толгой нь энэ зорилгодоо уурхайн хаалтын үед хүрсэн байхаар зорьж байгаа боловч төсөлхэрэгжих хугацаанд аль болох эрт хүрэх боломжуудыг эрэлхийлэх болно.*

Эерэг Нөлөөлөл Ахиу (ЭНА) үзүүлэх зорилгодоо хүрэхийн тулд Оюу Толгой биологийн олон янз байдлын бодлогодоо доорх зүйлсийг мөрдөж байна. Үүнд:

- Байгаль хамгааллын ач холбогдол бүхий биологийн олон янз байдлын бүрэлдэхүүн (Биологийн олон янз байдлын тэргүүн чухал бүрэлдэхүүн) ба төслийн зүгээс үзүүлж болзошгүй эрсдлийг тодорхойлох.
- Төсөлтэй холбоотойгоор биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, болон нөхөн сэргээх шатлалаар болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.
- Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах стратеги, Байгаль хамгааллын нэмэлт арга хэмжээнүүдийг Өмнийн говийн бүсийн хэмжээнд төлөвлөж хэрэгжүүлснээр биологийн

**Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө**

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1
--	---	------------------

олон янз байдалд үзүүлэх үлдэгдэл нөлөөллийг тодорхой хугацааны дараа нөхөн тэнцвэржүүлэх.

- Оюу Толгойн ЭНА үзүүлэх зорилгын биелэлтэд хяналт тавих, биологийн олон янз байдлын нөхцөл байдал, компанийн авч буй арга хэмжээний тохиромжтой байдлыг тодорхойлох боломжтой, хэмжигдэхүйц үзүүлэлт бүхий Мониторингийн хөтөлбөр боловсруулах.
- Төслийн ЭНА үзүүлэх зорилгын биелэлтийг хянах, нотлох шалгууруудыг боловсруулах, турших, хэрэгжүүлэх боломжийг бий болгох.
- Нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, зорилго, зорилтуудыг нэгтгэсэн Биологийн олон янз байдлын талаар авах арга хэмжээний хөтөлбөр (БОЯБХ) боловсруулах, уг хөтөлбөрийг Оюу Толгойн Байгаль орчны удирдлагын тогтолцоотой уялдуулах.
- Өмнийн говийн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн томоохон компанийн хувьд бүс нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалах ажилд манлайлагчийн үүрэгтэйгээр бусад уул уурхайн бүтээн байгуулалтын төслүүдтэй хамтрах замаар хавсарсан нөлөөллийг багасгахад анхаарах.
- Төслийн бүх үе шатанд биологийн олон янз байдлын холбогдолтой асуудалд сонирхогч талуудыг татан оролцуулах, хэлэлцүүлэг хийж санал бодлыг тусгах замаар нутгийн иргэд, төрийн болоод төрийн бус байгууллага, судалгаа шинжилгээний байгууллагуудыг хамруулсан ажил хэрэгч харилцааг төлөвшүүлэх
- Оюу Толгойн Биологийн олон янз байдлын талаар баримтлах стратегийг Оюу Толгойн байгаль орчин, нийгэм эдийн засгийн стратеги төлөвлөлттэй уялдуулах, нэгтгэх.

Рио Тинтогийн биологийн олон янз байдлын стратеги болон Оюу Толгойн биологийн олон янз байдлын стратегид ямарваа өөрчлөлт хийгдвэл Оюу Толгойн энэхүү удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт орж болно.

Тус удирдлагын төлөвлөгөөг Оюу Толгойн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (ЭМААБО) ерөнхий менежер хариуцна. Төслийн үйл ажиллагаа болон технологид орсон өөрчлөлтүүдийг тусгахын тулд удирдлагын төлөвлөгөөг шинэчилж болох бөгөөд жил бүр хянаж шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийх болно.

**1.4. Эхлэх огноо**

Тус удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 1 дүгээр сарын 1-нээс мөрдөж эхэлнэ.

**1.5. Эрх мэдэл ба удирдлага**

Оюу Толгойн удирдах зөвлөл тус удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр баталсан болно.

Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий менежер тус удирдлагын төлөвлөгөөг хариуцах бөгөөд Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөл хэрэгжилтийг хангах үүрэгтэйажиллана. Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд оруулах аливаа өөрчлөлтийн тухай хүсэлтийг ерөнхий менежерт тавих ба хүсэлтийг зохих ёсоор хянаж, баталсны гол дээр Өөрчлөлтийн хянан зохицуулалтын журмын дагуу өөрчлөлт хийнэ.

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

## **2. ХАМРАХ ХҮРЭЭ**

### **2.1. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ**

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Оюу Толгойн ашиглалтын шатны үед компаний болон гэрээт гүйцэтгэгч нар үйл ажиллагаандаа дагаж мөрдөх биологийн олон янз байдлын удирдлагын санаачлага, үүрэг, хариуцлагыг тодорхойлно. Ашиглалтын шатны биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөнд аливаа дэд бүтцийн өргөтгөлтэй холбоотойгоор газар хөндөх ажил хийж буй барилгын ажлын үед биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан болно.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг Олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ийн Гүйцэтгэлийн Стандарт 6, 2006 (ГС6) ба Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Гүйцэтгэлийн Шаардлага 6 (ГШ6) зэрэг стандартуудад нийцүүлэн боловсруулсан бөгөөд биологийн олон янз байдлыг (хамгааллын ач холбогдол бүхий чухал амьдрах орчны үнэлгээгээр тогтоосон арга хэмжээг мөн тусгасан) хамгаалах талаар баримтлах Оюу Толгойн үүрэг амлалтуудыг хэрэгжүүлэхэд удирдамжаар хангах зорилгоор боловсруулав. Мөн түүнчлэн энэхүү удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлсэнээр энэхүү баримт бичгийн 4.4 хэсэгт дэлгэрэнгүй тусгасан Монгол улсын холбогдох хуулийн шаардлагуудыг биелүүлж ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Тус менежементийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй оруулсан хамгааллын арга хэмжээнээс гадна Оюу Толгой нь Санхүүжүүлэгч байгууллагын стандартын шаардлагад нийцүүлэх зорилготой нэмэлт удирдлагын үйл ажиллагааг боловсруулсаныг энэхүү төлөвлөгөөнд Хавсралт-С болгон оруулав. Санхүүжүүлэгч байгууллагын шаардлагад нийцүүлэн боловсруулсан биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөрийн үйл ажиллагааг энэхүү төлөвлөгөөний Хүснэгт-2 д уялдуулж өгсөн байна.

Биологийн олон янз байдлын талаар баримтлах Рио Тинто корпорацийн стратеги (2008)-ийн дагууд боловсруулсан Оюу Толгойн биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөр (БОЯБХХ), стратегийг эцсийн байдлаар боловсруулсаны дараа энэхүү удирдлагын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх юм. Рио Тинтогийн шаардлагад нийцүүлж боловсруулах БОЯБХХ-ийг 2013 онд багтаан боловсруулах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эхний хувилбарыг 2013 оны 07 сарын 31-ны өдөр хийж дуусгаад байна. Эдгээр бүх удирдлагын төлөвлөгөө, хамгааллын хөтөлбөрийг нэгтгэсэнээр Оюу Толгой нь Монгол улсын хууль, ГС-6, ГШ-7, ба Рио Тинтогийн шаардлагуудад бүрэн нийцсэн нэгдсэн удирдлагаийг мөрдөж ажиллана.

Оюу Толгой төслийн ашиглалтын шатанд хэрэгжүүлэх биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ Рио Тинтогийн БОЯБХХ-д тусгагдана. Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийх замаар Рио Тинтогийн БОЯБХХ-д заасан биологийн олон янз байдлын зорилго, зорилт, үйл ажиллагаа болон үүрэг хариуцлагын дэлгэрэнгүйг Оюу Толгой төслийн Байгаль орчны удирдлагын тогтолцоонд уялдуулан нэгтгэх юм. Энэхүү төлөвлөгөөний Хүснэгт-2 д заасан үйл ажиллагаа нь Рио Тинтогийн БОЯБХХ-г эцэслэн батлах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд шинээр хийгдэх өөрчлөлтийг оруулж нэмэлт өөрчлөлт хийгдэх юм. Нэмэлт өөрчлөлтийг хийхдээ Өөрчлөлтийг хянан зохицуулах журам (ОТ-11-PRC-0001)-ыг мөрдлөгөө болгож Байгаль Орчин Нийгмийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0003) -ний бүрэлдэхүүн хэсэг байхаар зохицуулалтыг хийнэ.

Рио Тинтогийн БОЯБХХ нь биологийн олон янз байдлын тусгайлсан эрсдлийг үнэлсэний гол дээр нөлөөллийг бууруулах нарийвчилсан удирдлагын шийдлийг тус бүрт нь зааж өгнө. Түүнчлэн Рио Тинтогийн БОЯБХХ-ийг боловсруулахад олон улсын төдийгүй Монгол улсын нарийн мэргэжлийн зөвлөхүүдийн санал шүүмжийг бүрэн тусгаж өгнө. Рио Тинтогийн БОЯБХХ ба Оюу Толгойн Биологийн олон янз байдлын стратегийг биологийн олон янз байдлын олон улсын хөндлөнгийн шинжээчдийн тусламжтайгаар Оюу Толгойн монгол мэргэжилтнүүд боловсруулна. БОЯБХХ-г боловсруулахад Рио Тинто корпорацийн дагаж мөрддөг төлөвлөлтийн арга зүйн дагууд боловсруулах бөгөөд Глобал Биодиверсити Консервэйшн ТББ-ын туслалцаатайгаар боловсруулж байна.

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

Биологийн олон янз байдлын Дүйцүүлэн хамгааллын удирдлагын төлөвлөгөө нь хамрах цар хүрээ асар өргөн тул тусад нь боловсруулж хэрэгжүүлэх хэдий боловч энэхүү удирдлагын төлөвлөгөөтэй нарийн уялдаатай зохион байгуулах шаардлагатай.

Оюу Толгойн ашиглалтын шатанд зориулан боловсруулсан биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө дараах үйл ажиллагааг багтаасан:

- Олборлолт, эрдсийн баяжуулалт болон Оюу Толгойн холбогдох үйл ажиллагаа;
- Эцсийн бүтээгдэхүүн болон бараа материалын тээвэрлэлт;
- Төслийн хэрэгцээнд ашиглах нисэх буудлуудын үйл ажиллагаа;
- Усан хангамж;
- Цахилгаан үйлдвэрлэлт ба дамжуулалт;
- Ажилчдын амьдрах байр ба холбогдох дэд бүтэц.

Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс болох Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сумууд, Говийн бага дархан цаазат газрын А болон Б хэсгүүдэд зориулан чухал амьдрах орчныг тодорхойлохын<sup>1</sup> тулд тус удирдлагын төлөвлөгөөнд зориулан шинжилгээний хамгийн том нэгжийг багтаасан. Тус төлөвлөгөөнд тусгасан төслийн биологийн олон янз байдлын удирдлагын үйл ажиллагаа нь төслийн нөлөөллийн бүсийн өргөн хүрээнд биологийн олон янз байдалд нөлөөлөх Оюу Толгойн төслийн үйл ажиллагаа болон дэд бүтэцтэй холбоотой шууд нөлөөллүүдийг тусгасан.

Тус төлөвлөгөөнд Оюу Толгойн тусад нь боловсруулж байгаа Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийн удирдлагын төлөвлөгөөний тухай дэлгэрэнгүй мэдээллийг оруулаагүй. Тус төлөвлөгөөг БОННБҮ-ний С6-р бүлэгт тодорхойлсон Биологийн олон янз байдлын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2014 оны 3-р улиралд боловсруулж дуусгана.

Эргэлзээтэй байдлаас сэргийлэхийн тулд тус удирдлагын төлөвлөгөө нь дээр дурьдсан бусад биологийн олон янз байдлын төлөвлөгөөнүүдэд заагдсан чухал амлалтууд, удирдлагын арга хэмжээнүүдийг тусган Төслийн ашиглалтын шатанд дагаж мөрдөгдөх гол бичиг баримт болох бөгөөд Төслийн зээлдүүлэгчдийн аудитын шалгалтанд хамрагдана.

## **2.2. Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал**

Тус удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөний хүрээнд (лав: ОТ-10-ПЛН-0003) дурдсанчлан Оюу Толгой төсөлд зориулан боловсруулсан ашиглалтын шатны удирдлагын төлөвлөгөөнүүдийн нэг хэсэг юм. Тус төлөвлөгөөг Рио Тинтогийн зааврын тайлбарын (Хавсралт В) дагуу боловсруулсан Оюу Толгойн биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зориулан боловсруулагдсан юм.

Тус удирдлагын төлөвлөгөө нь дараах удирдлагын төлөвлөгөөнүүдтэй харилцан уялдаатай. Үүнд:

- Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөөтэй (лав: ОТ-10-Е9-ПЛН-0001) уялдана. Ялангуяа бэлчээрийн удирдлага, газрын нөхөн сэргээлт ба газрын эвдрэл доройтлыг бууруулах тухай хэсэгт;
- Ашиглалтын шатны усны эх үүсвэрий удирдлагын төлөвлөгөөтэй уялдана (лав: ОТ-10-Е10-ПЛН-0001), ялангуяа биологийн олон янз байдлын үнэ цэнэ болон экосистемийн үйлчилгээний хамгаалалтанд зориулсан усны эх үүсвэрийн удирдлагын хувьд;
- Ашиглалтын шатны тээврийн удирдлагын төлөвлөгөөтэй уялдана (лав: ОТ-10-С3-ПЛН-0001) тухайлбал амьтад дайрагдах, амьдрах орчны хуваагдлын нөлөөлөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх ба замгүй газраар зорчих;

<sup>1</sup> БОННБҮ-ний Хавсралт 3-т Чухал амьдрах орчныг тодорхойлох үнэлгээ

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

- Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөөтэй уялдана (лав: ОТ-10-Е7-PLN-0001), тухайлбал замын хажуугаар хог хаягдал хаяж хог хаягдлаар хооллодог зэрлэг ан амьтдыг татахаас сэргийлэх тухай;
- Оюу Толгой уурхайн хаалтын төлөвлөгөө (лав: ОТ-10-Е9-PLN-0002)

Оюу Толгой нь энэхүү удирдлагын төлөвлөгөөний Хүснэгт-2ын В02 заасан болон бусад үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Ханбогд сумын нутагт орших оролцогч талуудтай идэвхитэй хамтран ажиллана. Мөн бүс нутгийн хэмжээнд оролцогч талуудыг идэвхижүүлэх, биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөрийг нэгдмэлжүүлэх, нэн ялангуяа шугаман дэд бүтцүүдээс улбаатай амьдрах орчны хуваагдлын хам нөлөөллийг бууруулах чиглэлээр манлайлах үүрэгтэйгээр оролцох бодлого баримтална. Биологийн олон янз байдлын хамгааллалтай холбоотой хамтын оролцоотой үйл ажиллагааны дэлгэрэнгүйг Оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгаж өгөх бөгөөд тус төлөвлөгөөг 2013 оны 4-р улиралд багтаан шинэчилэн найруулна. Энэхүү шинэчлэлтийн ажлыг Оюу Толгойн Байгаль орчны хэлтэсийн Экосистемийн Үйлчилгээний Координатор нь хариуцан ажиллах бөгөөд Биологийн олон янз байдлын ерөнхий зөвлөх буюу Биологийн олон янз байдлын багийн ахлагч хяналт тавина.

### 3. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

#### 3.1. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол хариуцагчид, тэдгээрийн үүрэг

Тус төлөвлөгөөний хэрэгжилтийн гол үүрэг хариуцлагуудыг доорх хүснэгтэнд харуулав.

##### Хүснэгт 1: Гол хариуцагчид болон тэдгээрийн гүйцэтгэх үүрэг

Албан тушаал	Хариуцлага
Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> <li>• Тус удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ерөнхий хариуцлага</li> </ul>
Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх ба Биологийн олон янз байдлын ахлах ажилтан	<ul style="list-style-type: none"> <li>• Оюу Толгойн бүх ажилчид, гэрээт гүйцэтгэгч нарыг төлөвлөгөөгөөр хангах.</li> <li>• Биологийн олон янз байдлын асуудлаар эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий менежерт мэргэжлийн зөвлөгөө өгөх.</li> <li>• Биологийн олон янз байдлын асуудлаар ЭМААБО багийг удирдлагаар хангаж ажиллах,</li> <li>• Бүсийн Хөгжил Нийгмийн Гүйцэтгэлийн хэлтэс бас бусад дотоод ба гадны оролцогч талуудыг удирдлагын төлөвлөгөөнд тусгасан хамтын оролцоотой ажил үүргүүдийн хэрэгжилтийг хянан зохицуулах,</li> <li>• Биологийн олон янз байдлын шаардлагуудын гүйцэтгэлд хамааралтай зорилтуудыг боловсруулж холбогдох хэлтсүүдийн менежерүүдэд мэдээлэх.</li> <li>• Хэлтсүүдийн менежерүүдэд Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөний шаардлагуудад хамааралтай мэргэжлийн туслалцааг үзүүлэх.</li> <li>• Биологийн олон янз байдлын мониторинг, үнэлгээг тусгасан байгаль орчны тайланг улирал бүр ба жил тутам боловсруулах.</li> <li>• Тус төлөвлөгөөний шаардлагуудыг хангахын тулд зохих</li> </ul>



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

	<p>хөтөлбөрийг хэрэгжүүлж, зохицуулах.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Биологийн олон янз байдлын хариуцлага болон хуулиар хүлээсэн үүргүүдийн гүйцэтгэлд мониторинг хийж, тайлагнах.</li> <li>• Биологийн олон янз байдлын хамгаалалт ба дүйцүүлэн хамгааллын хэрэгжилтийн талаар төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн оролцогчидтой харилцан уялдаатай ажиллаж, зохицуулалт хийх.</li> <li>• Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар мэргэжлийн зөвлөгөө авахын тулд Биологийн олон янз байдлын зөвлөхүүдтэй хамтран ажиллах.</li> <li>• Оюу Толгойн биологийн олон янз байдлын зорилтуудад хүрэх хөтөлбөрийн үр дүнг үнэлэхийн тулд Биологийн олон янз байдлын зөвлөхүүдийг шаардлагатай мэдээллээр хангах.</li> <li>• Биологийн олон янз байдлын удирдлагын арга хэмжээг тус төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх.</li> </ul> <p>Оюу Толгойн ажилчид ба гэрээт гүйцэтгэгч нарыг тус удирдлагын төлөвлөгөөний шаардлагуудын тухай сургалт, заавраар хангах.</p>
<b>Бүх ажилчид ба гэрээт гүйцэтгэгч нар</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Тус төлөвлөгөөний ажил үүргийн тодорхой шаардлагуудад хамааралтай шаардлагуудыг хангаж ажиллах.</li> </ul>

### 3.2. Гол уялдаа холбоо

Тус удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол бүрэлдэхүүн хэсгүүд (Тус удирдлагын төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг танилцуулах үүрэг хариуцлага г.м.) дараах хэсгүүдээс бүрдэнэ:

- Бүсийн Хөгжил Нийгмийн Гүйцэтгэл, Тээвэр зохицуулалтын хэлтэс;
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс;
- Баяжуулах ба Дэд бүтцийн хэлтсүүд;
- Инженер/Засвар үйлчилгээний хэлтэс;
- Уурхайн ашиглалтын хэлтэс; ба
- Гадаад харилцаа/Засгийн газартай харилцах хэлтэс.

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

#### **4. ТӨСЛИЙН СТАНДАРТУУД**

Төслийн бүхий л үйл ажиллагаа холбогдох стандартуудад (Төслийн стандартууд) нийцэх шаардлагатай. Төслийн стандартууд дараах хэсгээс бүрдэнэ:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж;
- Монгол улсын холбогдох стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОННБУ) шаардлагууд;
- Монгол улсын засгийн газрын эрх бүхий байгууллагуудын тогтоосон бусад үүрэг хариуцлагууд;
- Зээлдүүлэгч байгууллагын холбогдох стандартууд; ба
- Рио Тинтогийн холбогдох стандартууд.

##### **4.1. Монгол улсын холбогдох хууль тогтоомж**

Биологийн олон янз байдлын хамгаалалтын тухай Монгол улсын хууль тогтоомжид дараах хуулиуд орно:

- 2000 онд хүчин төгөлдөр болсон Монгол улсын амьтны аймгийн тухай хуулийг хүчингүйд тооцож, 2012 оны 5 сарын 17-нд батлагдсан Амьтны тухай хуулийг мөрдөх болсон. Тус хуулийн зорилго нь амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх, зохистойгоор ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулинд амьтны аймгийг ашиглахад хязгаарлалт тогтоох тухай болон олон улсын байгаль хамгаалах холбооны Улаан дансанд орсон ховор болон нэн ховор зүйлийг бүртгэх, амьдрах орчин ба нүүдэллэх замыг хамгаалах, агнуурын нөөц газар бий болгох, сүргийн нөөцийг өсгөх болон дахин нутагшуулах тухай заалтуудыг багтаасан.
- 1995 оны 6 сарын 5-нд хүчин төгөлдөр болж, 2010 оны 12 сарын 9-нд шинэчлэн найруулсан Байгалийн ургамлын тухай хуулийн зорилт нь ойгоос бусад байгалийн ургамлыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль байгаа бөгөөд энэ нь нэн ховор, ховор ба элбэг ургамлуудыг ашигласан төлбөрийн хэмжээг тогтоодог. Ашиглах тусгай зөвшөөрлийг олгох үед тухайн сум ба дүүрэгт төлбөр төлөх боломжтой. Төсөл нь Байгалийн ургамлын тухай хуулиар хамгаалагдах ургамлын төрөл зүйл бүхий газарт оршдог.
- Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1995 оны 4 сарын 1-нд хүчин төгөлдөр болж, 2008 оны 12 сарын 19-нд нэмэлт өөрчлөлт оруулсан) нь тусгай хамгаалалттай газар нутгийн газрын зориулалт, худалдан авалт болон ховор болон нэн ховордсон амьтдыг хамгаалахын тулд байгалийн унаган нөхцлийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн дагуу тусгай хамгаалалттай газар нутаг дараах дөрвөн ангилалд хуваагддаг: Дархан цаазат газар, Байгалийн цогцолборт газар, Байгалийн нөөц газар ба Дурсгалт газар. Оюу Толгой төслийн талбайгаас Гашуун сухайтын хилийн шалган нэвтрүүлэх цэг хүрэх зам нь Говийн бага дархан цаазат газрын дундуур дайрч өнгөрдөг тул, замын ашиглалт, удирдлагийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу зохицуулна.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн тухай хуулиар (1997 оны 10 сарын 23-нд хүчин төгөлдөр болсон) дархан цаазат болон байгалийн цогцолбор газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоохын тулд Тусгай хамгаалалттай газрын болон дархан цаазат газрын орчим Орчны бүс байгуулахыг шаарддаг. Тус хууль Орчны бүсүүд болон түүний хил хязгаарыг тогтооход ашигласан шалгуурыг тодорхойлсон ба Орчны бүсийн зөвлөл, түүний бүтэц, үүрэг хариуцлагыг тусгасан. Түүнчлэн Орчны бүсийн санг орчны бүсүүдэд болон орон нутгийн иргэдийн ахуй амьдралыг баталгаажуулахад дэмжлэг үзүүлэхийн тулд байгуулсан. Мөн тус хуулиар Орчны бүсийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах тухай зааж, Орчны

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

бүсийн хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд авах хариуцлагыг тогтоосон. Говийн бага дархан цаазат газрын (ГБДЦГ) А ба Б хэсгүүдийн эргэн тойронд Орчны бүс тогтоосон байдаг. Оюу Толгой төслийн талбайгаас Гашуун сухайтын хилийн шалган нэвтрүүлэх цэг хүрэх зам ГБДЦГ-ын дундуур дайрч өнгөрдөг тул замын ашиглалт, удирдлагыг Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн тухай хуулийн заалтуудаар зохицуулна. Орчны бүсийн тухай хуулийн заалтууд дараах үйл ажиллагааг хориглодог:

- Ерөнхий төлөвлөгөө ба зураг төсөлд нийцээгүй суурин газрын өргөтгөл, барилга байгууламжийг барьж байгуулах;
- Ашигт малтмал малтах, хайх, олборлох буюу зам гаргах гэх мэтээр орчны бүсийн төлөв байдлыг өөрчлөх;
- Шавьж хорхой, мэрэгчидтэй тэмцэх болон гал түймрээс сэргийлэх зорилгоор байгаль орчинд хор хөнөөл учруулахуйц аливаа арга, технологи, бодис ашиглах.

#### **4.2. Монгол улсын холбогдох стандартууд**

Монгол улсын стандарт, хэмжилзүйн үндэсний төв үндэсний стандартуудыг боловсруулдаг. Дор дурдсан стандартуудад нөхөн ургамалжуулах, хөрс сайжруулах болон уурхайн нөхөн сэргээлт гэх мэт биологийн олон янз байдалтай холбоотой асуудлуудыг тусгасан:

- MNS 0017-5-1-19:1992 Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийхэд тавих ерөнхий шаардлага;
- MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд тавигдах ерөнхий шаардлага;
- MNS 4915:2000 Техникийн шаардлага. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний давхаргыг тодорхойлох.
- MNS 4919:2000 Байгаль орчин. Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага;
- MNS 4920: 2000 Байгаль орчин. Эвдэрсэн газрын хажуу налуу. Техникийн шаардлагууд;
- MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт;
- MNS 5915:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт ;
- MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт. Техникийн шаардлага;
- MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага;
- MNS 5918: 2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага.

#### **4.3. БОНБНУ-ий шаардлагууд**

Биологийн олон янз байдалд холбогдох Оюу Толгойн хууль ёсны үүрэг хариуцлагыг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Ашигт малтмалын тухайн хуулиудын дагуу боловсруулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан.

Ашиглалтын үе шатны биологийн олон янз байдалд хамааралтай БОНБНУ-нүүдийг дор хураангуйлан үзүүлсэн:

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

- Оюу Толгой-Гашуун сухайтын дэд бүтцийн зурвасын БОНБНУ;
- Гүний хоолойн усан хангамжийн шугам хоолойн БОНБНУ;
- Оюу Толгойн байнгын нисэх буудлын БОНБНУ;
- Усны нөөцийн БОНБНУ;
- Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ.
- Ундай голын урсацад хэсэгчилсэн тохируулга хийх төслийн БОНБНУ

Энэхүү төлөвлөгөөний Хүснэгт-4 д төслийн БОНБНУ-ний тайлангуудад тусгасан биологийн олон янз байдлын хамгаалалтай холбоотой гол заалтуудыг хураангуйлан оруулсан болно.

#### **4.4. Монгол улсын засгийн газрын эрх бүхий байгууллагын бусад үүрэг хариуцлага ба шаардлагууд**

- Монгол улсын засгийн газар биологийн олон янз байдлыг хамгаалахтай холбоотой олон улсын хэд хэдэн конвенцид нэгдэн орсон. Тэдгээр конвенциуд Оюу Толгойн төсөлд шууд хамааралгүй боловч тэдгээр нь засгийн газрын бодлоготой холбоотой ойлголт өгөх чухал мэдээлэл болно. Монгол улсын Засгийн Газрын нэгдэн орсон биологийн олон янз байдалтай холбоотой конвенциуд нь: Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенци ("ЗАНЗХТК") (1983 оны 11 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон);
- Африк болон Евроазийн махчин шувуудыг хамгаалах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг (2008 оны 11 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон);
- Бөхөнг хамгаалах тухай Харилцан ойлголцлын санамж бичиг (2006 оны 9 сарын 24-нд хүчин төгөлдөр болсон);
- Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци (1996 оны 12 сарын 29-нд хүчин төгөлдөр болсон);
- Биологийн олон янз байдлын тухай конвенци (БТЗТК) (1993 оны 12 сарын 29-нд хүчин төгөлдөр болсон);
- Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци (CITES) (1973 оны 3 сар);
- Европын зэрлэг амьтад ба амьдрах орчныг хамгаалах тухай (Бернийн конвенци) конвенци (1979 он, 1982 оны 6 сарын 1-нд хүчин төгөлдөр болсон).

##### **4.4.1. Хөрөнгө оруулалтын гэрээ**

Хөрөнгө оруулалтын гэрээний 6.4, 6.9, 6.10 болон 6.11 заалтууд хамааралтай:

- Хөрөнгө оруулагч нь Оюу Толгой төслийн хэрэгжилттэй холбоотой Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /цаашид "БОХТ" гэх/, орчны мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах жил бүрийн бүх зардлыг хариуцах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд дурдсан арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаа тухай хараат бус, мэргэшсэн, эрх бүхий хөндлөнгийн шинжээчийн тайланг 3 /гурав/ жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- Хөрөнгө оруулагч нь гол үйл ажиллагаатайгаа холбоотой байгаль орчны мониторингийн иж бүрэн үнэлгээний хөтөлбөрийн тайланг жил тутам байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Байгаль орчны мониторингийн хөтөлбөрөөр агаар, ус, хөрс, амьтан, ургамал болон газрын хэвлийд аливаа материаллаг сөрөг нөлөөлөл үзүүлсэн нь тогтоогдвол Хөрөнгө оруулагч уг нөлөөллийг арилгах шаардлагатай арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ. Оюу Толгой төслийн үйл ажиллагаанаас шууд шалтгаалан урьдчилан тооцоолоогүй болон нөхөж болшгүй байгаль, экологийн сөрөг нөлөөлөл, хохирол учирвал уг хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлсон хэмжээ, экологи-эдийн засгийн үнэлгээг үндэслэн Хөрөнгө оруулагч нөхөн төлнө.

#### **4.5. Олон улсын холбогдох стандарт болон удирдамжууд**

ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6 нь Биологийн олон янз байдлыг хамгаалах тухай конвенцийн зорилтууд болох биологийн олон янз байдлыг хамгаалах ба байгалийн сэргээгдэх нөөцийг тогтвортой ашиглах явдлыг дэмжих зэрэг зорилтуудыг тусгасан.

Тус гүйцэтгэлийн стандартын зорилтууд нь:

- Биологийн олон янз байдлыг хадгалан хамгаалах;
- Байгаль хамгаалах хэрэгцээ шаардлага ба хөгжлийн зорилтуудыг нэгтгэн уялдуулсан туршлагыг нэвтрүүлэх замаар байгалийн нөөц баялгийг тогтвортой удирдаж, ашиглах явдлыг дэмжин дэлгэрүүлэх үйл ажиллагаа юм.

ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн стандарт 6 биологийн олон янз байдлыг авч үздэг ба дараах зорилтуудтай: биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, шаардлагатай үед биологийн олон янз байдлыг "цэвэр алдагдалгүй" байлгах зорилгоор их хэмжээний үлдэгдэх нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах явдал юм.

Оюу Толгой төсөл нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 6-гийн 10-р заалт ба ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 6-гийн 14-р заалтын шаардлагуудыг дагаж мөрдөнө.

#### **4.6. Рио Тинтогийн холбогдох стандартууд**

Оюу Толгой нь Байгаль орчны бодлогод<sup>2</sup> тусгасны дагуу биологийн олон янз байдлыг хамгаалах үүрэгтэй.

Рио Тинтогийн биологийн олон янз байдлыг хамгаалах үүргийг компанийн Биологийн олон янз байдлын стратегид<sup>3</sup> тодорхойлсон.

Оюу Толгой төсөлд зориулан төслийн Биологийн олон янз байдлын стратегийг<sup>4</sup> (Хавсралт А) боловсруулсан ба энэ нь Рио Тинтогийн стратегид нийцнэ.

Тус стратеги нь өмнийн говийн бүс нутгийн биологийн төрөл зүйлийн Эерэг Нөлөөлөл Ахиу'үзүүлэхэд хүрэх (ЭНА) Оюу Толгойн зорилгыг тусгасан.

<sup>2</sup> Оюу Толгойн байгаль орчны бодлого, 2004 он

<sup>3</sup> Рио Тинто болон биологийн олон янз байдал: Газар дээр үр дүнд хүрэх, 2008 он

<sup>4</sup> Оюу Толгой ХХК-ий Биологийн олон янз байдлын бодлого: Нийтлэг үндэслэл, 2011 оны 9 сар

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

## 5. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ

Дор Хүснэгт 2-т авч үзсэн ашиглалтын үе шатны биологийн олон янз байдлын удирдлагын хяналтуудыг Оюу Толгойн БОННБУ-нд үнэлсэнчлэн нэн тэргүүний чухал биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлөх чухал болон өндөр эрсдэл бүхий болзошгүй нөлөөллүүдийг бууруулахын тулд боловсруулсан (БОННУ-ний С6 бүлгийн хүснэгт 6.9-д заасны дагуу). Биологийн олон янз байдлын удирдлагын арга хэмжээний үр дүнг үнэлэх хянах мониторингийн хөтөлбөрийг Оюу Толгой боловсруулж хэрэгжүүлэх юм. БОННУ-нд тусгасан нөлөөллийг бууруулах арга хэмжээний нэгтгэл хүснэгтийг энэхүү удирдлагын төлөвлөгөөний хавсралт D-д оруулж өгсөн байгаа.

Биологийн олон янз байдлын дунд болон бага эрсдэл бүхий болзошгүй нөлөөллүүдэд (БОННУ-ний С6 бүлгийн 6.5-д заасан) зориулсан удирдлагын нэмэлт хяналтуудыг дараах удирдлагын бусад төлөвлөгөөнүүдэд оруулсан. Үүнд:

- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е10-ПЛН-0001);
- Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е12-ПЛН-0001);
- Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е9-ПЛН-0001);
- Хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е7-ПЛН-0001);
- Гэрээт гүйцэтгэгчийн удирдлагын хөтөлбөр (ОТ-07-ПЛН-0001);
- Уурхайн хаалтын төлөвлөгөө (ОТ-10-Е19-ПЛН-0002);
- Дуу шуугиан чичирхийллийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е6-ПЛН-0001)
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-ПЛН-0001).

Хүснэгт 2-т үзүүлсэн удирдлагын гол хяналтууд нь нэмэлт зам, цахилгаан дамжуулах шугам, газар хөндөлт шаардах Оюу Толгойн уурхайн бүхий л үе шатуудын турш явагдах барилгын ажилд зориулсан үйл ажиллагаануудыг мөн багтаасан. Оюу Толгой зэрлэг ан амьтдад зориулсан нүхэн гарцуудыг Гашуун Сухайт – Оюу Толгойн замын эхний шатны ажил дуусч, ашиглалтанд орсны дараа барихаар төлөвлөж байгаа тул тэдгээр гарцууд нь барилгатай холбоотой чухал төсөл юм. Зэрлэг амьтдад зориулсан нүхэн гарцуудыг автозамын барилгын ажлыг хийж гүйцэтгэх явцад зэрэг барьж байгуулах боломжуудыг эрэлхийлж ажиллана. Төслийн үйл ажиллагааны явцад зохион байгуулах аливаа барилгы ажлын үеэр биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээг ӨХЗ журам (ОТ-11-PRC-0001) болон ГХЗ журам (ОТ-10-Е9-PRC-0003)-н дагуу үнэлж, нарийвчлан тогтоож байх болно.

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон удирдлагын хяналтуудаас гадна Оюу Толгой зээл олгогч нарын холбогдох стандартуудыг хангахын тулд биологийн олон янз байдлын хэд хэдэн шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээсэн. Тэдгээр үүргүүдийг тус төлөвлөгөөний Хавсралт С-гийн Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд хавсаргасан. Тус Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан үүргүүд нь дор үзүүлсэн Хүснэгт 2-т орсон ашиглалтын удирдлагын арга хэмжээтэй нийцдэг. Оюу Толгой мөн Рио Тинтогийн Биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөр боловсруулах зааврын (Хавсралт В) дагуу Рио Тинтогийн Биологийн олон янз байдлын хамгааллын хөтөлбөрийг 2013 онд боловсруулах үүрэг хүлээсэн ба тус төлөвлөгөөг Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээр үндэслэн Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсон Өөрчлөлтийг хянан зохицуулах журмуудын (ОТ-11-PRC-0001) дагуу хянах шаардлагатай.

Тус удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилт нь Оюу Толгойн ажилчид, гэрээт гүйцэтгэгч нарын Биологийн олон янз байдлын удирдлагатай холбоотойгоор өдөр тутам дагаж мөрдөх үйл ажиллагааны журмуудад илүү дэлгэрэнгүй тусгагдана. Үүнд:

- Зэрлэг амьтан, ургамлын хууль бус бүтээгдэхүүнийг илрүүлэх, хянан шалгах бодлого (ОТ-10-Е9-PLC-0001) (Боловсруурагдаж байгаа)
- Зам, цахилгааны шугамыг хянан шалгах журам (ОТ-16-PRC-0006);
- Төслийн талбайд мөрдөгдөх тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PRC-0005);
- Бэлчээрийн удирдлагын стратеги (ОТ-10-Е2-ПЛН-0001);

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

- Нөхөн сэргээлтийн журам (ОТ-10-Е9-PRC-0002);
- Өнгөн хөрс хуулах, хадгалах журам (ОТ-10-Е9-PRC-0001);
- Газар хөндөх зөвшөөрөл олгох журам (ОТ-10-Е9-PRC-0003).

Оюу Толгойн төлөвлөгөөнүүдийг Рио Тинтогийн газар ашиглалтын хариуцлагын стандартад нийцүүлэх үүднээс Газар ашиглалтын төлөвлөгөөний (ОТ-10-Е9-ПЛН-0001-Е) хэрэгжилтийг дэмжин Газар ашиглалтын хэрэгжилтийн төлөвлөгөөг боловсруулна. Энэ нь цаашдаа Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөөтэй холбогдоно.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

### Хүснэгт 2: Удирдлагын гол хяналтууд

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
B01	Дэд бүтцээс амьтад үргэж дайжсанаар амьдрах орчин шууд бусаар алдагдах	Хууль бус агнуурын болзошгүй өсөлт	Оюу Толгой төслийн ажилчид, гэрээт гүйцэтгэгч нар үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа хууль бус ан хийхийг хориглосон шийдвэрийг тусгасан Зэрлэг ургамал, амьтдын хууль бус бүтээгдэхүүний тухай Оюу Толгойн бодлогыг хэрэгжүүлэх (ОТ-10-Е9-PLC-1001). Энэхүү журмыг сургалтын хөтөлбөрүүдээр дамжуулан Оюу Толгойн ажилчид болоод гэрээт гүйцэтгэгч нарт танилцуулна.	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх	Төслийн ажилчид, гэрээт гүйцэтгэгчид Оюу Толгойн Зэрлэг ургамал, амьтдын хууль бус бүтээгдэхүүний тухай бодлогыг зөрчсөн тохиолдлуудын бүртгэл (жишээлбэл автомашин болон агаарын тээврийн хяналт шалгалтын бүртгэл, хууль бус бараа бүтээгдэхүүнтэй холбоотой осол зөрчлийн бүртгэл, ажилчидын байранд хийсэн шалгалтын бүртгэл)	Тогтмол
			Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх болон сургалтын хэлтэс	Төслийн нөлөөллийн бүс дэхь хууль бус ан агнуурыг Оюу Толгойн Биологийн олон янз байдлын мониторинг үнэлгээний хөтөлбөрийн хүрээнд хөндлөнгийн	Тогтмол	
			Бодлогыг бүх ажилчдад (төслийн ажилчид ба гэрээт гүйцэтгэгч нар) сургалт явуулах журмаар танилцуулах		Тогтмол	



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
					<p>мэргэжилтнүүдтэй хамтран хянах</p> <p>Сургалтын бүртгэл</p>	
B02	<p>Дэд бүтцээс амьтад үргэж дайжсанаар амьдрах орчин шууд бусаар алдагдах</p> <p>Экосистемийн үйлчилгээ</p>	<p>Хууль бус агнуурын болзошгүй өсөлт</p> <p>Автомашинд мөргүүлснээс үүдэх зэрлэг ан амьтдын хорогдол</p> <p>Тээврийн хэрэгслүүд замын дагуу олноор зогсох</p> <p>Автомашинууд замгүй газраар зорчих</p>	<p>Доорх Биологийн олон янз байдалтай холбоотой асуудлуудыг Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд тусгах:</p> <p>Оюу Толгой төслийн нөлөөллийн бүс (БОННБҮ-нд тусгасан) ялангуяа Ханбогд сумын нутагт хууль бус ан агнуурыг бууруулах зорилгоор орон нутгийн болон бүсийн оролцогч нартай хамтран ажиллана. Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөг 2013 оны хоёрдугаар улиралд багтаан шинэчилнэ.</p> <p>Оюу Толгой – Гашуун сухайт чиглэлийн авто зам дээр тохиромжтой хурдны дээд хязгаарыг (Оюу Толгой компанийн хурдны дээд хязгаарын хамтаар) мөрдүүлэх үүднээс орон нутгийн гол оролцогч талуудтай хамтарч ажиллана. (ТМР29);</p>	<p>Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх</p> <p>Оюу Толгойн Бүсийн хөгжил, нийгмийн гүйцэтгэлийн хэлтэс</p> <p>Оюу Толгойн Бүсийн хөгжил, нийгмийн гүйцэтгэлийн хэлтэс гол оролцогч нартай хамтран ажиллана</p> <p>Биологийн олон янз байдлын нөхөн хамгааллын ерөнхий зөвлөх тохирох саад буюу хийц болон хамгааллын ач</p>	<p>Талуудын оролцооны бүртгэл</p> <p>Оролцогч талуудын хамтын ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт</p> <p>Замын аюулгүй ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт</p>	<p>Тогтмол</p> <p>Тогтмол</p> <p>Тогтмол</p>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
			<p>Аваар ослын тохиолдол болон алжаал тайлахаас бусад нөхцөлд замын хажууд тээврийн хэрэгслүүдийг зогсоохгүй байх (Тээврийн удирдлагын төлөвлөгөө - TMP-05-г харна уу).</p> <p>Оюу Толгой – Гашуун сухайт, Оюу Толгой – Ханбогд болон Оюу Толгойн нисэх буудал зэрэг чиглэлийн замуудад зэрлэг амьтад зам хөндлөн гарах боломжтой байхын сацуу автомашинууд замаас гарх боломжгүй хаалт хийх хэсгүүдийг тодорхойлох, тохиромжтой инженерийн хийцийг бий болгох</p>	холбогдолтой чухал газар нутгийг тодорхойлох үүрэгтэй	Талуудын оролцооны бүртгэл	Тогтмол
B03	Дэд бүтцээс амьтад үргэж дайжсанаар амьдрах орчин шууд бусаар алдагдах Экосистемийн үйлчилгээ	Тээврийн хэрэгслүүд замын дагуу олноор зогсох	Аваар ослын тохиолдол болон алжаал тайлахаас бусад нөхцөлд замын хажууд Оюу Толгойн тээврийн хэрэгслүүдийг зогсоохгүй байх (Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PLN-0001) - TMP-05-г харна уу).	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий менежер	Аялалын удирдлагын систем (GPS хяналтын төхөөрөмж гэх мэт)	Тогтмол
B04	Амьдрах орчны шууд бус алдагдал ба амьдрах орчны	Дэд бүтэц болон замгүй газраар явж байгаа автомашинууд	<p>Оюу Толгой нь Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу:</p> <p>(i) Оюу Толгой – Гашуун Сухайт, Оюу Толгой – Ханбогд болон Оюу</p>	Оюу Толгойн барилгын хэлтэс тэдгээр саадуудыг барих үүрэгтэй; Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа,	Хяналтын хөтөлбөрийн тайлан	Эцсийн нэг тайлан

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
	хуваагдал үүсэх  Ан агнуур болон түүж цуглуулах явдлаас үүдэн үүсэх хорогдол  Экосистемийн үйлчилгээ	аас дайжих  автомашинууд замгүй газраар зорчих нь ихсэх	Толгой -нисэх буудал зэрэг чиглэлийн замуудаас тээврийн хэрэгслийг гарахыг хориглох зорилгоор нөлөөлөлд өртөгч газар нутгийг хамгаалах хаалт, байгууламжуудыг барих ажлын төлөвлөгөө боловсруулах.  (ii) Байгууламж, инженерийн хийцийг суурилуулах.	байгаль орчны хэлтэс мониторинг хийх үүрэгтэй  Биологийн олон янз байдлын нөхөн хамгааллын ерөнхий зөвлөх	Саадуудыг суурилуулж засвар үйлчилгээ хийсэн эсэхийг шалгах	Жилд 2 удаа засвар үйлчилгээ хийх
B05	Ан агнуур болон түүж цуглуулах явдлаас үүдэн үүсэх хорогдол  Экосистемийн үйлчилгээ	Дэд бүтэц сайжирсаны улмаас нэмэгдэх	Төслийн нийт ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарыг түлшээр хангаж, орон нутгаас мод түүх хэрэгцээг таслан зогсоох (жишээлбэл заг)	Бүсийн хөгжил, нийгмийн гүйцэтгэлийн хэлтэс	Ажилчид болон гэрээт гүйцэтгэгч нарт түлш олгосон бүртгэл	Сар бүр  Тогтмол
B06	Ан агнуур болон түүж цуглуулах явдлаас үүдэн үүсэх хорогдол	Дэд бүтцийн улмаас нэмэгдэх	Оюу Толгойн Зэрлэг ургамал, ан амьтны хууль бус бүтээгдэхүүний тухай бодлогыг хэрэгжүүлж, төслийн онгоц, автомашинуудад хууль бусаар агнасан амьтны бүтээгдэхүүн зөөвөрлөхөөс сэргийлж шалгалт хийх	Оюу Толгойн аюулгүй байдлын хэлтэс	Зөрчлийг илрүүлэх хяналт шалгалтын бүртгэл	Тогтмол

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
B07	Шууд хорогдол	Автомашинд мөргүүлэх	Оюу Толгой төслийн хүрээнд Биологийн олон янз байдлын чухал бүрдэл хэсгүүдийн (туруутан болон шувууд) талаар Оюу Толгойн бүх жолооч болон гэрээт гүйцэтгэгч нарт ажлын байрны сургалт явуулах, жолооч нарт мэдээлэл түгээх (Тээврийн удирдлагын төлөвлөгөө - TMP08, TMP10-г харна уу)	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин болон сургалтын хэлтэс	Жолооч нарын сургалтын бүртгэлүүд	Тогтмол
						Тогтмол
B08	Шууд хорогдол	Автомашинд мөргүүлэх	Анхааруулах тэмдгүүд зэрлэг амьтад замаар хөндлөн гарч болзошгүйг анхааруулсан тэмдгүүдийг тусгасан эсэхийг шалгах (Тээврийн удирдлагын төлөвлөгөө TMP06-г харна уу)	Оюу Толгойн барилгын хэлтэс Оюу Толгойн дэд бүтцийн хэлтэс	Тэмдгүүдийг суурилуулж засвар үйлчилгээ хийсэн эсэхийг шалгах.	Сар бүр
B09	Шууд хорогдол	Цахилгаан дамжуулах шугамыг мөргөх, хүчдэлд цохиулснаас үүдэх хорогдол	Цахилгаан дамжуулах шугамын босго шалгуурыг боловсруулж хэрэгжүүлэх: <ul style="list-style-type: none"> <li>• Шувуу үргээгчийг цахилгаан эрчим хүч дамжуулах бүх шугамуудад байрлуулах (далбант болон мушгиа нислэг чиглүүлэгчийг солбиж байрлуулна. Ялгарах өнгүүдийг 10-20 м тутамд сөөлжүүлж, байрлууна. өөрөөр хэлбэл 5-10 м тутамд нислэг чиглүүлэгч өлгөнө).</li> <li>• Дунд хүчдэлийн цахилгаан эрчим хүчний шугамын шонгууд, төгсгөл, дэд станц болон өндөр хүчдэлийн шонгуудын</li> </ul>	Оюу Толгойн барилгын хэлтэс	Барилгын гүйцэтгэлийн бүртгэлүүд Цахилгаан дамжуулах шугамын үзлэг шалгалтын бүртгэлүүд (B07.3-г харна уу)	Тогтмол
				Оюу Толгойн барилгын хэлтэс	Барилгын гүйцэтгэлийн бүртгэлүүд Цахилгаан дамжуулах шугамын үзлэг шалгалтын бүртгэлүүд (B07.3-г харна уу)	Тогтмол
				Оюу Толгойн барилгын хэлтэс	Цахилгаан дамжуулах	Тогтмол

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
			<p>шаардлагатай хэсгүүдийг тусгаарлагч суурилуулна (EDM-ийн зөвлөх мэргэжилтний зөвлөмжийн дагуу)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шувууны нислэг чиглүүлэгч болон тусгаарлагчийг үйл ажиллагааны турш шаардлагын дагуу ашиглаж, ан амьтны үхэл хорогдлыг бууруулах.</li> </ul>	хэлтэс, Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс	шугамын үзлэг шалгалтын бүртгэлүүд (B07.3-г харна уу)	Тогтмол
B10	Амьдрах орчин шууд алдагдах  Экосистемийн үйлчилгээ	Дэд бүтцийн улмаас	<p>Оюу Толгой газрын нөхөн сэргээлтийг Оюу Толгойн Нөхөн сэргээлтийн журам, Газар ашиглалтын хэрэгжилтийн төлөвлөгөө, Уурхайн хаалтын төлөвлөгөөнд тодорхойлсон арга, үйл явцын дагуу болон Оюу Толгойн Газар ашиглалтын удирдлагын төлөвлөгөө, Рио Тинтогийн Газар ашиглалтын хариуцлагын стандартад заасан зарчим, шаардлагуудын дагуу гүйцэтгэнэ.</p> <p>Эвдэрсэн газар, хаасан замын нөхөн сэргээлтэд мониторингийн хөтөлбөртэй ажиллана</p>	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх	<p>Гүйцэтгэлийн шалгуурыг хангасан эсэхийг шалгахын тулд газрын нөхөн сэргээлтийн бүртгэлийг шалгах</p> <p>Нөхөн сэргээгдсэн газар ба ашигласан аргачлалыг шалгахын тулд газрын нөхөн сэргээлт/газрын эвдрэл доройтлын бүртгэлийг шалгах</p> <p>Нөхөн сэргээлтийн чанарын дүн шинжилгээ (хөрсний нөхцөл ба тогтворжилт), ургамалжилтын үзүүлэлтүүд (зүйлийн бүрэлдэхүүн, нягтшил,</p>	<p>Тогтмол</p> <p>Тогтмол</p> <p>Тогтмол</p>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
					<p>бүрхэц), амьдрах орчны олон талт нөхцөл</p> <p>Нөхөн сэргээлтийн талбай дахь Биологийн олон янз байдлын болон шувуудын үүрлэлтийн ажиглалт</p> <p>Нөхөн сэргээлтийн үр дүнд харь зүйлийн ургамлууд түрэн ургахгүй байхыг баталгаажуулан байнгын хяналт хийх</p>	
B11	Хорогдол ихэсэх	Махчин амьтдын тоо өсөх	Шувуудын сэгийг өндөр хүчдэлийн шугам болон замаас зайлуулж (Оюу Толгойн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагын дагуу) баримтжуулах. (Цахилгаан дамжуулах шугамын үзлэгийн журам ба ТМР15 Оюу Толгойн зам барилга, засварын журам ОТ-10-С3-PRC-0001-Е-г харна уу).	Цахилгааны шугамын үзлэг шалгалт, цахилгааны засвар; Замын үзлэг, шалгалт зам засвар	<p>Тогтмол үзлэг хийгдэж байгаа ба шувууны сэг, үүрийг зайлуулсныг баримтжуулсан эсэхийг шалгахын тулд цахилгаан дамжуулах шугамын үзлэгийн бүртгэлийг шалгах.</p> <p>Тогтмол үзлэг хийгдэж байгаа ба шувууны сэг, үүрийг зайлуулсныг баримтжуулсныг шалгахын тулд замын үзлэг, засварын бүртгэлүүдийг шалгах</p>	<p>Сар бүр</p> <p>Сар бүр</p>

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
B12	Хорогдол ихэсэх	Махчин амьтдын тоо өсөх	Замын урсгал засвар, үзлэгийн үеэр Оюу Толгойн бүх замуудын дагуу байх хог, хүний үйл ажиллагаагаар үүссэн хог хаягдлыг нутгийн иргэдийн Нүүлгэн шилжүүлэх Хөтөлбөрт хамрагдсан ажилчдын оролцоотойгоор шалгаж, зайлуулах	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ажлын хөтөлбөрүүдийн бүртгэл	Долоо хоног бүр
B13	Хорогдол ихэсэх	Махчин амьтдын тоо өсөх	Идлэг шонхороос бусад тоодог шувууг ангуучлагч махчин шувуудын үүрийг төслийн дэд бүтцээс зайлуулах (Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагуудын дагуу). Цахилгааны шугам болон дэд бүтцийн үзлэгийн бусад журмуудыг хэрэгжүүлэх (үзлэгийн журмуудыг боловсруулж байгаа)	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс Цахилгааны засвар үйлчилгээний хэсэгтэй хамтран зөвлөлдсөний гол дээр зохицуулалт хийнэ	Төслийн дэд бүтцээс шувуудын үүргийг зайлуулсан тухай бүртгэлүүд	Үржлийн Улиралд сар бүр
B14	Ургамлын гарц болон нөхөн үржих чадвар буурах	Ургамал дээр буух тоосжилтын улмаас	Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөг (AQ02, 03 болон 04) хэрэгжүүлэн тоосонд хяналт тавина.	Төслийн бүх ажилтнууд, хэлтсүүд нь төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосны ялгаралтыг бууруулах үүрэгтэй. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс төслийн бүх үйл ажиллагаанд зориулан тоосны мониторинг хийж, бүртгэл хөтөлнө	Ургамлын мониторингийн мэдээлэл (Бэлчээрийн болон нөхөн сэргээлтийн талбайд жил бүр хийгдэх 37 цэг)	АЧМТ-г харна уу

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
B15	Зэрлэг амьтдын эрүүл мэнд, нөхөн үржихүйд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Тоосжилтонд өртсөний улмаас	Агаарт ялгарах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөөг (AQ02, 03 болон 04) хэрэгжүүлэн тоосонд хяналт тавих талаархи мэдээлэл цуглуулна.	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс	Орон нутгийн иргэдийн мал амьтны эрүүл мэнд, нөхөн үржихүйтэй холбоотой гомдлын бүртгэл  Биологийн олон янз байдлын мониторингийн хүрээнд хийгдэх Зэрлэг амьтдын үхэл хорогдлын тэмдэглэл	АЧМТ-г харна уу
B16	Амьдрах орчны шууд бус алдагдал ба популяцийн хэсэгчлэн хуваагдал	Тээврийн үйл ажиллагаанаа с болж газар нутаг хоорондын нэгдмэл байдал багасах	Оюу Толгой нь: <ul style="list-style-type: none"> <li>• Ан амьтдад зориулсан нүхэн гарцыг харилцан зөвшөөрсөн хугацаанд Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу барьж дуусгах</li> </ul>	Оюу Толгойн барилгын хэлтэс нүхэн гарцын суурилуулалт ба инженерийн шийдлийг хариуцна. Нүхэн гарцын зураг, төсөл байршлыг Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтсээс зөвлөгөө авсны гол дээр сонгох	Нүхэн гарцын барилгын гүйцэтгэлийн тайлан  Нүхэн гарцын засвар үйлчилгээний бүртгэл	Тогтмол
B17	Нөлөөллийн үнэлгээ ба биелэлт		Оюу Толгой нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд тусгагдсан Биологийн олон янз байдалтай холбоотой бүх хамгаалалын болон удирдлагын үйл ажиллагаанууддаа	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын ерөнхий зөвлөх	Бүртгэл	Тогтмол



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Хүрээ	Хэрэглээ/Үйл ажиллагаа	Хяналтын тодорхойлолт	Хариуцсан талууд	Гүйцэтгэлийн шалгуур	Давтамж
			<p>дотоодын бүртгэл хийнэ. Бүртгэлд дараах зүйлсийг хамруулна:</p> <ul style="list-style-type: none"> <li>Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын системд хийгдсэн арга хэмжээнүүдийг бүргэнэ</li> <li>Сөрөг нөлөөллийг бууруулах болон бусад арга хэмжээ хийгдээгүй болон үргэлжлээгүй тохиолдлуудыг цаг хугацааны хамт бүртгэнэ</li> </ul>			
B18	Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөө		Оюу Толгой нь Биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ (Хавсралт С-гээс харна уу)	Биологийн олон янз байдлын ерөнхий зөвлөх	Хяналт шалгалтын тэмдэглэл	Тус төлөвлөгөөнд заасны дагуу

Тайлбар: Биологийн олон янз байдлын хамгаалалтай холбоотой Гэрээт ажил эрхлэгчдийн шаардлага нь ажлын захиалга хийгдэх үед эрсдлийн удирдлагын явцад тодорхойлогдоно. Биологийн олон янз байдалтай холбоотой шаардлагууд нь ажлын гэрээ бүрийн агуулгад тусгагдана. Гэрээт гүйцэтгэгчид шаардлагатай сургалтанд хамрагдах ба тэдний гүйцэтгэлийг Оюу Толгой байнга хянаж шалгах эрхтэй.

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

## 6. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

### 6.1. Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэл

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг жил бүр хянах ба урган гарах нөхцөл байдал болон Оюу Толгойн үйл ажиллагаанаас үүдэн гарах хэрэгцээг тусгах нэмэлт өөрчлөлтүүдийг хийнэ. Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны ерөнхий менежер тус удирдлагын төлөвлөгөөг хянаж, шалгах үүрэгтэй.

Хэрэв (Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын системд тусгасан Өөрчлөлтийг хянан зохицуулах журмын дагуу тодорхойлсончлон) үйл ажиллагааны журмуудад нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай бол, тус удирдлагын төлөвлөгөөнд шаардлагын дагуу нэмэлт өөрчлөлт оруулна.

## 7. МОНИТОРИНГ

### 7.1. Мониторингийн шаардлагуудын тойм

Ашиглалтын шатанд төслийн стандартуудыг (Хэсэг 4: Төслийн стандарт-ыг харна уу) хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд хийх мониторингийн арга хэмжээг тус хэсэгт тодорхойлсон.

Мониторингийн явцад төслийн стандартуудыг зөрчсөн нь тогтоогдвол, тэдгээрт магадлан шинжилж, засч залруулах зохих арга хэмжээг авах болно (Оюу Толгойн эрүүл мэнд, байгаль орчин ба аюулгүй ажиллагааны удирдлагын системийг харна уу).

### 7.2. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

Биологийн олон янз байдлын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг үр дүнтэй хэмжиж тодорхойлохын тулд дор дурдсан гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг боловсруулсан.

#### Хүснэгт 3: Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд

ID	Гүйцэтгэлийн гол үзүүлэлт	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
В-KPI 01	Биологийн олон янз байдлын үнэлгээ ба Газар хөндөх зөвшөөрлийн баталгаажилтын журмын дагуу зөвшөөрөлгүй эвдрэлд орсон газар	Газар хөндөх зөвшөөрлийн үнэлгээ ба баталгаажилтын шаардлагатай 100% нийцүүлэх	Төслийн хөндөгдсөн газруудыг Газар хөндөх зөвшөөрлийн бүртгэл ба зөвшөөрлийн шаардлагуудын гүйцэтгэлийн үнэлгээний дагуу жил тутам шалгах.
В-KPI 02	Оюу Толгойн зэрлэг ан амьтан, ургамлын хууль бус бүтээгдэхүүний тухай бодлоготой нийцэх	100% нийцэх	Автамашин, онгоцуудад ан амьтны гаралтай бүтээгдэхүүнийг шалгасан тухай бүртгэл; хууль бус ан агнуур болон түүж цуглуулсан бүтээгдэхүүнийг хураасан тухай тайлан.
В-KPI 03	Байгаль орчны мэдлэг олгох сургалтанд	Сургалтанд суусан ажилчдын 100% нь	Оюу Толгойн болон гэрээт ажилчдын сургалтын бүртгэл

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Гүйцэтгэлийн гол үзүүлэлт	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
	хамрагдаж буй ажилчдын хувь	ажлын эхний 6 сарын хугацаанд сургалтанд хамрагдсан.	
В-KPI 04	Оюу Толгойн ажилчид, гэрээт ажилчид зөвшөөрөлгүйгээр замгүй газраар зорчсон болон замын хажууд машинаа тавьсан тохиолдлууд	Ажилчид болон гэрээтүүд зөвшөөрөл авалгүйгээр замгүй газраар жолоодох болон замын хажууд машинаа тавих тохиолдол гаргахгүй байх.	Оюу Толгойн автомашинууд зөрчил гаргаагүй эсэхийг шалгахын тулд автомашины GPS хяналтыг системийг шалгаж, Оюу Толгойн автомашин/жолоочийн хяналтын бүртгэлийг шалгах. Автомашинууд замгүй газраар явах болон замын хажууд машинаа тавих явдлыг бууруулахын тулд Биологийн олон янз байдлын мониторинг болон үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж буй хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын ажлын цар хүрээндээ тусгасан олон нийтийн хөтөлбөрүүдийн ололт амжилтыг шалгах. Зөвшөөрөлгүйгээр замгүй газраар зорчсон осол зөрчлийн бүртгэл
В-KPI 05	Цахилгааны шугам болон замуудаас шувууны сэг ба махчин амьтны үүрийг зайлуулах	Шувууны сэг ба үүрийг 100% үзлэгийн болон сэг зайлуулах журмуудын дагуу хэрэгжүүлэх.	Цахилгааны шугам болон замын үзлэг шалгалтын бүртгэлүүд
В-KPI 06	Газрын нөхөн сэргээлтийн хөтөлбөрийг Газар ашиглалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн	Газрын нөхөн сэргээлтийн жилийн төлөвлөгөөний дагуу 100% хэрэгжүүлэх.	Газрын нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ Газрын нөхөн сэргээлтийн жилийн аудит
В-KPI 07	Зэрлэг ан амьтанд тохиолдох үхэл хорогдлын холбогдолтой осол зөрчил	Тэг осол зөрчил	Осол зөрчлийн тоо Осол зөрчлийн тайлангууд
В-KPI 08	Төслийн нөлөөллийн бүсийн хэмжээнд ялангуяа Ханбогд сумын хэмжээнд хууль бус ан агнуурыг бууруулах	Суурь судалгаагаар тогтоосон хэмжээгээр мэдэгдэхүйц их хэмжээгээр хууль бус агнуурын үйл ажиллагааг бууруулах (хууль бус агнуурын хэмжээг тодорхойлох суурь судалгааг хийж тодорхой тоо хэмжээ тогтоосон зорилго тавьж	Оролцогч талуудын хамтын ажиллагааны тайлангууд  Хууль бус агнуурын хяналт шалгалтын тайлан

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

ID	Гүйцэтгэлийн гол үзүүлэлт	Зорилт	Мониторингийн арга хэмжээ
		ажиллана)	
В-KPI 09	Зэрлэг амьтдад зориулсан нүхэн гарцыг Туруутан амьтад ашиглаж буй байдал	Амьтдыг дамжин өнгөрүүлэх зорилготой нүхэн гарцын хэрэглээ, амьдрах орчны холбоос болох илтгэцүүр	Нүхэн гарцын хяналт шалгалтын мэдээ, тайлан, дүн шинжилгээ
В-KPI 10	Оюу Толгой – Гашуун сухайт, Оюу Толгой – Ханбогд болон Оюу Толгойн нисэх буудал чиглэлийн замаас гаран зорчих тээврийн хэрэгслийн тоо	Оюу Толгойн холбогдолтой замуудаас гаран зорчих тээврийн хэрэгслийн тоог тэглэх	Замын хаалт хашилтын мониторингийн мэдээ, тайлан <i>Оюу Толгой нь үе үе Биологийн олон янз байдлын хамгаалалтын арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэхэд хяналт тавина.</i>
В-KPI 11	Хяналт шалгалтын зорилтуудыг хамтран төлөвлөх	Оюу Толгойн байгаль орчны хэсгийн удирдлагууд, судалгааны ахлах ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид хоёр жилд нэг удаа уулзан хяналт шалгалтын хөтөлбөрийг хэлэлцэх	Жил бүрийн хяналт шалгалтын хөтөлбөрийн ажлын төлөвлөгөө
В-KPI 12	Сайрын дагуух хайлаасан шугуй болон заган ойн эрүүл мэндийн мониторинг	Сайрын дагуух Хайлаас болон заган ойн популяцийн эрүүл мэнд сайжрах, тоо толгой нэмэгдэх	Сайрын дагуух хайлаас ба загийг шугаман трансектын аргаар гүйцэтгэж, үхсэн болон унасан моддын хувийг тоолно
В-KPI 13	Ундайн булгийн нөхцөл байдлын үнэлгээ	Бор-Овоо булгийг нүүлгэн шилжүүлэн шинээр бий болгосон булаг нь гадаргын болон гүний урсац, улирлын хэлбэлзэл зэрэг экологийн үйл явцын хувьд өмнөхтэйгээ төстэй байх	Суурь мэдээллээс хэлбэлзсэн хэмжилтийн мэдээ болон Хөх хад булагтай харьцуулсан судалгааны дүн (усны мониторингийн төлөвлөгөөнөөс дэлгэрэнгүйг харна уу)

### 7.3. Мониторингийн гол үйл ажиллагаа

#### 7.3.1. Биологийн олон янз байдлын мониторингийн гол хөтөлбөр

Ашиглалтын үе шатанд хэрэгжүүлэх биологийн олон янз байдлын мониторингийн арга хэмжээг Биологийн олон янз байдлын мониторинг ба үнэлгээний хөтөлбөрийн (ВМЕР) дагуу хэрэгжүүлнэ.

Оюу Толгой нь урт хугацааны Биологийн олон янз байдлын мониторинг ба үнэлгээний хөтөлбөрийг (ВМЕР) 2015 он гэхэд боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Мониторинг, үнэлгээний хөтөлбөр нь дараах зорилтуудтай:

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

1. Уян хатан удирдлагаийг хэрэгжүүлж, биологийн олон янз байдалд нөлөөлөх нөлөөллийг бууруулахын тулд боловсруулах, сөрөг нөлөөллийг бууруулах ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний (эерэг ба сөрөг) нөлөөллүүдийг боломжийн хэрээр үнэлэх;
2. Төсөл нь биологийн олон янз байдлын өндөр үнэ цэнэ бүхий төрөл зүйл болон орчинд урт хугацаанд Эерэг нөлөөлөл ахиу (ЭНА) үзүүлж байгааг харуулах.

Оюу Толгой нь биологийн олон янз байдлын суурь төлөв байдлын тухай яаралтай шаардагдаж буй мэдээллийг нөхөхийн тулд 2013-2014 онуудад биологийн олон янз байдлын гол мониторинг боловсруулан хэрэгжүүлэх болно. 2013 онд хэрэгжүүлэх биологийн олон янз байдлын гол мониторинг нь урт хугацааны биологийн олон янз байдлын мониторинг ба үнэлгээний хөтөлбөрт (ВМЕР) ноцтой өөрчлөлт илрэх босго хэмжээний талаар мэдээлэл өгөхүйц биологийн төрөл зүйлд илрэх байгалийн өөрчлөлт, нөлөөллийн цар хүрээ (эерэг ба сөрөг)г ойлгох суурь нөхцлийг бий болгохыг зорих болно.

Биологийн олон янз байдлын мониторингийн гол хөтөлбөрийн хүрээг Оюу Толгой мэргэшсэн, туршлагатай хөндлөнгийн байгууллагуудад хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд нь зориулан боловсруулсан. Тус ажлын хүрээнд тодорхойлсон биологийн олон янз байдлын гол хөтөлбөрийн гол үйл ажиллагаа дараах үйл ажиллагаанаас бүрдэнэ:

- Биологийн төрөл зүйлийн өндөр үнэ цэнэ бүхий бүрэлдэхүүн хэсгүүдэд гарах өөрчлөлтийн зохих үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээр үзүүлэлтүүдэд мониторинг хийх практик аргачлалуудыг тодорхойлох;
- Өөрчлөлтийг урт хугацаандаа статистикийн хувьд сайтар тодорхойлох боломжтой, биологийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн хэсгүүдэд гарах байгалийн жамаар гарах өөрчлөлтийн цар хүрээг тогтоож, Оюу Толгойн үйл ажиллагаанд боломжийн хэрээр өөрчлөлт оруулах боломжтой дүн шинжилгээний системийг боловсруулж, хэрэгжүүлэх (төслийн нөлөөлөл ба сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүхлээр нь ойлгохын тулд);

Биологийн олон янз байдлын мониторингийн гол хөтөлбөр нь дор хаяж биологийн олон янз байдлын дараах үнэ цэнэ бүхий бүрэлдэхүүн хэсгүүдийнтөлөв байдал, тэдгээрт учирч буй дарамт болон хариу өөрчлөлтийн үзүүлэлтүүдийг тусгах болно. Үүнд:

- Хулан (*Equus hemionus*);
- Аргаль (*Ovis ammon*);
- Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*);
- Жороо тоодог (*Chlamydotis undulate*);
- Могойч загалай (*Circaetus gallicus*);
- Идлэг шонхор;
- 18 'нэн ховор' ургамлууд (*Монгол буурцгана Chesniella mongolica гэх мэт*);
- Боржин чулуун гаршууд дээрх ургамлын бүлгэмдлүүд;
- Сайрын дагуух хайлаасан шугуй;
- Өндөр ургасан заган ой;
- Бэлчээр.

Биологийн олон янз байдлын гол хөтөлбөрийн (БОЯБҮХ) зорилго нь ирээдүйд БОЯБҮХ-д мэдээлэл өгөх зорилгоор мониторингийн шалгуур үзүүлэлтүүдэд 'байгалийн жамаараа' гарах өөрчлөлтүүдийг ойлгох мөн тухайн өөрчлөлтүүдийн хүлцэж болох хэмжээ (хэрэв энэ хэмжээг хэтэрвэл сөрөг нөлөөлөл бууруулах хариу арга хэмжээнд өөрчлөлт хийхболно) зэргийн талаар мэдээлэл өгнө.

Биологийн төрөл зүйлийн өндөр үнэ цэнэ бүхий бүрэлдэхүүн хэсэг бүрийн болзошгүй нөлөөллийн цар хүрээ болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний газарзүйн талбайн хэмжээнд мониторинг хийх болно. Зарим бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд, мониторингийн хамрах хүрээ төслийн дэд бүтцийн хувьд орон нутгийн шинж чанартай байж болно. Туруутан амьтад гэх мэт өргөн уудам газар нутагт бэлчдэг бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд, мониторинг нь дор хаяж Ханбогд сумын өргөн зурвас газар, Гүний Хоолойн ус дамжуулах шугам хоолойн талбай, Гашуун сухайтын хилийн шалган нэвтрүүлэх цэг (цооног болон дамжуулах хоолой,

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

уурхайн талбайг Ханбогд сумтай холбосон дэд бүтэц ба уурхайн талбайг Хятадын хилтэй холбосон зам ба цахилгаан дамжуулах шугам) хүртэлх нутаг дэвсгэрийг хамарна.

Хол газар бэлчдэг биологийн төрөл зүйлүүдэд нөлөөлөх нөлөөллүүд нь төслийн дэд бүтцээс тодорхой зайнд мэдрэгдэх боломжтой ба мониторинг нь тэдгээр болзошгүй нөлөөлөл бүхий газар нутгийг хамрах болно. Түүнчлэн, хяналтын талбайд хийх мониторинг суурь өөрчлөлт ба төслийн нөлөөлөл/сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнээс үүссэн өөрчлөлт гэж ангилна. Тухайлбал, мониторингийн гол системийг боловсруулахад дараах болзошгүй нөлөөллүүдийг харгалзан үзнэ:

- Амьдрах орчны шууд алдагдал;
- Дэд бүтцээс ан амьтад үргэж дайжсаны улмаас үүдсэн амьдрах орчны шууд бус алдагдал;
- Заг ба хайлаасыг их хэмжээгээр огтлон түлшинд хэрэглэснээс үүсэх амьдрах орчны шууд бус алдагдал.
- Амьтдын популяцийн хэсэгчлэн хуваагдал (амьдрах орчны холбоос буурах);
- Шууд үхэл хорогдол (автомашинд мөргүүлснээс болон өндөр хүчдэлийн шугамын цахилгаанд цохиулснаас);
- Ан агнуур болон мод огтлох ургамал түүж цуглуулах явдал ихэссэнээс үүсэх шууд бус хорогдол;
- Байгаль дахь махчин амьтдын тоо толгой нэмэгдсэнээр үүсэх шууд бус үхэл хорогдол;
- Уст давхаргын түвшин буурснаас бэлчээр, хайлаасан шугуй болон заган ойн чанар муудах

### **7.3.2. Гидрологийн тодорхойгүй байдлыг тооцоолох мониторинг**

Одоо байгаа мэдээлэл дээр үндэслэн Оюу Толгойн БОННБУ-ий дүнд төслийн нөлөөллийн бүсийн (Ундай гол орно) хэмжээнд гадаргын ус болон хөрсний уст давхаргуудад маш бага хэмжээний сөрөг нөлөөлөл үүсгэнэ гэж таамаглаж байгаа боловч тэр таамаглалын үндэслэлийг шалгахын тулд мониторинг тогтмол хийх шаардлагатай. Тус таамаглал нь уурхайн газар хөндөлтийн улмаас нилээд хэмжээний шууд нөлөөлөлд өртөх Бор Овоо булгийн нөлөөллийг тусгаагүй.

Гидрологийн тодорхойгүй байдлыг тодорхойлох мониторинг хийх нь биологийн олон янз байдалд учрах эрсдлийг шалгахад чухал ач холбогдолтой бөгөөд тэдгээр нөлөөллийн тохиолдох магадлал ихэсэхэд тухайн эрсдлүүдэд чиглэсэн арга хэмжээ авах боломж олгодог. Хэрвээ төсөл гадаргын ус болон хөрсний уст давхаргуудад сөрөг нөлөөлөл үзүүлэх нь тогтоогдвол, тус мониторинг нь ирээдүйн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Ийм зорилгоор Оюу Толгой нь Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөөний (ОТ-10-Е10-PLN-0001) Хүснэгт 5-д дурдсанчлан гүний усны мониторингийн хөтөлбөр хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн ба тус мониторинг нь дараах нөлөөллүүдийг тодорхойлох болно:

- Гадаргын болон аллювийн уст давхаргад уурхайн шавхалтаас болж үүсэх төслөөс хамааралтай нөлөөллүүд;
- Ундай голын урсгалын гадаргын гидрологид болон гүний усны түвшинд нөлөөлөх төслийн нөлөөллүүд;
- Гүний хоолойн ай савын Цэрдийн уст давхаргын усыг ашигласнаар гадаргын болон аллювийн гүний усны түвшинд үзүүлэх нөлөөлөл;
- Гүний хоолойн ай савын Цэрдийн уст давхаргын усыг ашигласнаар Галбын говийн уст давхаргын гүний усны түвшинд үзүүлэх нөлөөлөл;
- Дөрөлж уулын өмнөд хэсэг орших уст давхаргын усыг ашигласнаар гадаргын болон аллювийн гүний усны түвшинд үзүүлэх нөлөөллүүд.

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-ПЛН-0003-М	Хувилбар: 1.1

БОННУ-г хийж дуусахаас өмнөх хугацаанд Дөрөлж уулын өмнөд хэсэгт орших уст давхаргаас Ханбогд сумын хөгжил, хүн амын унд ахуйд зориулан авч ашиглах усны хэмжээ нь маш бага хэмжээтэй буюу  $>100\text{м}^3$ /хоногт байна. Хэдий тийм боловч БОННУ-нд төсөлтэй холбогдох бүхий л нөлөөллийн үнэлгээ, тэдгээрээс улбаатай болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тусгаж өгсөн болно (БОНУАХ-г үзнэ үү).

### **7.3.3. Ашиглалтын үеийн биологийн олон янз байдлын сөрөг нөлөөллийг бууруулах гол арга хэмжээнүүдтэй холбоотой мониторинг ба БОНБНУ-гээр батлагдсан ургамал, амьтны мониторингийн хөтөлбөрүүд**

Оюу Толгой нь биологийн олон янз байдлын мониторинг ба үнэлгээний хөтөлбөрийг (ВМЕР) боловсруулах хүртэл барилгын үе шатнаас өмнө боловсруулсан ургамал, амьтны мониторингийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Дор үзүүлсэн хүснэгт 4-т Оюу Толгойн хэрэгжүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулах гол хяналтууд болон төслийн барилгын үе шатны өмнө эхлүүлсэн мониторингийн үйл ажиллагааны үргэлжлэлтэй холбоотой биологийн олон янз байдлын мониторингийн үйл ажиллагааг үзүүлсэн. Хүснэгт 4-т үзүүлсэн мониторингийн үйл ажиллагааны ихэнхи хэсэг нь БОНБНУ-ний явцад батлагдсан хуулиар хүлээсэн үүргүүдтэй холбоотой. Хүснэгт 4-т үзүүлсэн мониторингийн үйл ажиллагаануудыг 2013 онд хэрэгжиж эхлэх Оюу Толгойн биологийн олон янз байдлын мониторинг ба үнэлгээний төлөвлөгөөний загвар болон хэрэгжилтийн дагуу сайтар хянах болно. Энэхүү хянах процессийн дагууд энэхүү төлөвлөгөөний 7.3.1. хэсэгт тодорхойлсон хамгааллын ач холбогдол, үнэ цэнэ бүхий хэмээн тодорхойлсон биологийн олон янз байдлын 11 бүрдэл хэсгүүдийн төлөв байдал, учирч буй дарамт, хариу үйлдэл бүрийг дэлгэрэнгүй хянах төлөвлөгөөг шинэчилэн найруулна. Мониторингийн хөтөлбөрийн үр дүнг жил бүр тайлагнах болно.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

### Хүснэгт 4: Мониторингийн гол хэмжилтүүд

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
FFM-01	Зэрлэг ан амьтдын гэмтэл/үхэл хорогдол	<p>Байгаль орчны хэлтэс амьтны аймагтай холбоотой бүх осол зөрчлийг бүртгэж авах ба тус хэлтэс нь мөн хамгаалах шаардлагатай төрөл зүйлүүдийн ажиглалтын мэдээг тэмдэглэж авах үүрэгтэй</p> <p>Зэрлэг амьтад болон гэрийн тэжээмэл амьтдын үхэл хорогдлыг бүртгэнэ (жишээ нь, тээврийн хэрэгсэлд мөргүүлэх, үйлдвэрийн осол болон бусад эх үүсвэрээс үүдсэн хорогдол).</p>	Тогтмол Сар бүр бүртгэлийн тайланг Байгаль орчны хэлтэс нэгтгэн боловсруулж	Төслийн нөлөөллийн бүсийн доторх бүх талбай
FFM-02/B11/ B13/B15	Зэрлэг ан амьтдын гэмтэл/үхэл хорогдол	<p>Сар бүрийн шалгалтын үед дунд хүчдэлийн ба өндөр хүчдэлийн эрчим хүчний шугамд цохиулсан амьтдын сэг болон шувууны үүрийг тэмдэглэх</p> <p>Шувууны нислэг чиглүүлэгчийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих</p> <p>Жороо тоодгийг барьж иддэг махчин шувуудын үүрийг төслийн дэд бүтцүүдээс буулгах, зайлуулах</p>	<p>Сар бүр үзлэг шалгалтыг эхлээд 6 сар тутам, дараа нь жилд нэг удаа хийх</p> <p>Сар бүр</p> <p>Сар бүр</p>	<p>Цахилгаан дамжуулах шугамууд</p> <p>Цахилгаан дамжуулах шугамууд</p> <p>Цахилгаан дамжуулах шугамууд</p>
FFM-03	Ан амьтдын ажиглалт	<p>Сонгогдсон газруудад тогтмол шалгалт хийх, зэрлэг ан амьтдыг тоолох зэрэг ажлуудыг хийх бөгөөд үүндээ зохих ёсоор мэргэшсэн мэргэжилтнүүдийг татан оролцуулна. Эдгээр шалгалт, тооллогууд нь доорхи төрлийн амьтдын тоо толгой, байршлыг тогтоох юм:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Том ба жижиг хөхтөн</li> </ul>	Сар бүр	12 мониторингийн цэг (шувууд ба сээр нуруугүй амьтад) ба нүүдлийн төрөл зүйл болон хэвлээр явагчдын хувьд УЛТ–ын эргэн тойрны нэмэлт цэгүүд



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
		<ul style="list-style-type: none"> <li>▪ Шувууд (нүүдлийн шувууд багтана)</li> <li>▪ Хэвлээр явагчид</li> <li>▪ Сээр нуруугүй амьтад</li> </ul>		Усны цооногийн талбай ба ус дамжуулах шугам хоолой болон мөн Оюу Толгой – Гашуун Сухайтын дэд бүтцийн зурвасын дагуу
FFM-04	Ургамлын туршилт судалгааны цэгүүд	Бэлчээрийн доройтол болон цаг уурын үзэгдэл ургамлан бүрхэвчид үзүүлэх урт хугацааны нөлөөллийг судлахын тулд УЛТ-д тогтоогдсон цэгүүдэд ургамлын мониторинг үргэлжлүүлэн хийнэ. 2003 оны 5 сараас хойш тус мониторинг 6 сар тутамд хийж байгаа. Энэхүү мониторингээр аливаа гадны зүйл ургамал байгаа эсэх мөн тэдгээрийн үр дагавар зэргийг багтаана.	Уурхайн ажиллах бүхий л хугацааны туршид, 6 сар тутамд	Усны цооногийн талбай, ус дамжуулах шугам хоолой болон Оюу Толгой – Гашуун сухайтын дэд бүтцийн зурвас дагуух бусад цэгүүд.
FFM-05/B12	Нөхөн сэргээлт	<p>Ургамлыг нөхөн сэргээлтийн нөхцөл ба нөхөн сэргээгдсэн байдалд мониторинг хийнэ .</p> <p>Дараах аргуудыг ашиглан нөхөн сэргээлтийн үр дүнг шалгаж болно:</p> <ul style="list-style-type: none"> <li>▪ Талбайн газрын гадаргын функцийн дүн шинжилгээ (хөрсний нөхцөл ба ашиглахад бэлэн болгох байдал), ургамлын бүрхэвчийн хөдлөл зүй (төрөл зүйлийн бүтэц, нягтшил ба бүрхэвч), ба амьдрах орчны нөхцөл байдал;</li> <li>▪ Нөхөн сэргээлт хийгдсэн газруудад биологийн төрөл зүйлүүд болон шувууны үүр байгаа эсэхэд ажиглалт хийх</li> <li>▪ Нутгийн унаган биш харь зүйл ургамлын мониторинг хийж төсөл нь тус зүйлийн тархалтанд хүргэхгүй байх явдлыг хангах</li> </ul>	Цэг тус бүр дээр тодорхойлно.	Эвдэрсэн газрууд, түүний дотор нөхөн сэргээгдсэн зам харгуй
FFM-06	Ховор	Ховор ургамлын тархалт ба нягтшил	Жил бүр	Оюу Толгойн лицензит талбай ба төслийн

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
	ургамлууд			нөлөөллийн бүст
FFM-07	Өндөр заг мод болон хайлаас	Хайлаас модны тоо хэмжээ ба оршин тогтнох нөхцөл  Хайлаас мод ба заган ойн тоо хэмжээ ба оршин тогтнох нөхцөл	мэргэжлийн судлаачийн зөвлөмжийн дагуу тогтмол	Оюу Толгойн лицензит талбайн зүүн хэсэгт уурхайн ус шавхаснаас үүсэх усны түвшин буурах магадлалтай бүс. Ундай голын голдирол өөрчлөгдсөн хэсгээс цаашааурсгалын дагууд
B01/02/08	Хууль бус ан агнуурын өсөлт	Оюу Толгой нь Зэрлэг ургамал, амьтдын хууль бус бүтээгдэхүүний тухай бодлогынхоо хүрээнд хууль бусаар ан агнах, ургамал түүхийг хориглоно. Төслийн талбайд гарсан зөрчлийг дараах байдлаар хянана: <ul style="list-style-type: none"> <li>• Хулгайн ангийн суурь үнэлгээг тогтоох</li> <li>• Хулгайн ангийн эсрэг авах арга хэмжээг тодорхойлох</li> <li>• Хулгайн ангийн эсрэг арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн үр дүнг хянах</li> </ul>	Тогтмол  Тогтмол  Тогтмол	Оюу Толгойн нөлөөллийн талбай   Оюу Толгойн нөлөөллийн талбай   Оюу Толгойн нөлөөллийн талбай
B03/B05	Дэд бүтцээс амьтад дайжсанаар амьдрах орчин шууд бусаар алдагдах	Оролцогч талуудтай дараах байдлаар хамтран ажиллана: <ul style="list-style-type: none"> <li>• Оюу Толгой – Гашуун Сухайт чиглэлийн замыг олон нийт ашиглах үед тохиромжтой хурдны хязгаарыг баримтлахыг шаардах</li> <li>• Мөн замын хажуугаар тээврийн хэрэгсэл зогсохыг бууруулах</li> </ul>	Тогтмол	Оюу Толгойн нөлөөллийн талбай
B04/09	Оюу Толгойн тээврийн хэрэгслийн	Аваар ослын тохиолдол болон алжаал тайлахаас бусад нөхцөлд замын хажууд Оюу Толгойн тээврийн хэрэгслүүдийг зогсохыг хязгаарлах.	Тогтмол	Оюу Толгойн нөлөөллийн талбай

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
	улмаас амьтдын амьдрах орчин шууд бусаар алдагдах болон шууд хорогдол	Оюу Толгойн бүх ажилчид, гэрээт гүйцэтгэгчдийг биологийн олон янз байдлын талаар жолоочийн ухамсрыг дээшлүүлэх сургалтанд хамруулна.	Тогтмол	
B06	Амьтдын амьдрах орчин шууд бусаар алдагдах, амьдрах орчны хуваагдал, үхэл хорогдол нэмэгдэх	Оюу Толгой – Гашуун Сухайт, Оюу Толгой – Ханбогд болон Оюу Толгойн нисэх буудал зэрэг чиглэлийн замуудаас автомашин гарахаас сэргийлсэн хэд хэдэн төрлийн хаалт, хашилт байгуулах.  Хаалт хашилтууд нь ямар үр дүнтэй байгааг судлах, хянах.  Замуудын дагуу хамгийн их анхаарал татсан хэсгүүдэд автомашин гарахаас сэргийлэн үр дүнтэй байгаа хаалт хашилтуудыг суурилуулах	Тогтмол  Тогтмол  Тогтмол	Оюу Толгойн замууд
B07	Ургамлын аймаг	Оюу Толгойн бүх ажилчид, гэрээт гүйцэтгэгчдэд гэрт хэрэглэх өөр төрлийн түлшээр хангах	Тогтмол	Төслийн талбайн хэмжээнд
B14	Махчин амьтдын тоо өсөх	Оюу Толгойн замуудын дагуу хүний үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, хяналт шалгалт хийх.	Долоо хоног бүр	Оюу Толгойн замууд
B18	Амьтдын амьдрах орчин шууд бусаар алдагдах ба хуваагдах	Зэрлэг амьтдын популяцийг хуваагдахаас сэргийлэн нүхэн болон зам дээгүүрх гарцуудыг байгуулах .  Нүхэн болон зам дээгүүрх гарцуудыг зэрлэг амьтад хэрхэн ашиглаж буйд байнгын хяналт тавих, хяналтын үр дүнг ашиглан дараагийн барих байгууламжийн загвар хийцийг тодорхойлох.	Тогтмол	Оюу Толгой – Гашуун Сухайтын чиглэлийн зам
Дэд бүтцийн	Амьтны популяци ба	Дэд бүтцийн зурвасын эргэн тойрны 20 км-т судалгаа хийх. Газар хөндөлтөөс өмнөх газар ашиглалт ба үнэлгээг	10-11 сар болон 4-5 сарын шилжилт	

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
БОНБНУ	шилжилт хөдөлгөөн	харьцуулахын тулд холбогдох тоо хэмжээг бүртгэх.	хөдөлгөөн	
Дэд бүтцийн БОНБНУ	Ургамлын бүрхэвч	Ургамлын бүрхэвчид мониторинг хийж, Улаан номонд орсон төрөл зүйлүүд, нутгийн унаган болон реликт ургамлуудыг тэмдэглэх. БОНБНУ-ний Хавсралт 8-д дурдсан аргачлалыг ашиглах.	Жил бүрт 7 сард	Нөхөн сэргээсэн нүх болон барилгын ажил дууссан газрууд
Усан хангамжийн БОНБНУ	Ургамлын бүрхэвчийг дахин сэргээх	Ус дамжуулах хоолойн дагуу 25 м <sup>2</sup> талбайн төрөл зүйлийн нягтшил ба олон янз байдалд мониторинг хийж, дамжуулах хоолойн хүний үйл ажиллагаанд бага өртсөн 2 км-ийн дагуу нягтшил, олон янз байдалтай харьцуулах.	Жил бүрт 7 сард	5 байршил
Усан хангамжийн БОНБНУ	Амьтны популяци ба шилжилт хөдөлгөөн	Дэд бүтцийн зурвасын эргэн тойрны 20 км-т судалгаа хийх. Газар хөндөлтөөс өмнөх газар ашиглалт ба үнэлгээг харьцуулахын тулд холбогдох тоо хэмжээг бүртгэх.	Жил бүрт 7 сард	
Гүний усны нөөцийн БОНБНУ	Ургамалд үзүүлэх нөлөөлөл	Гидрогеологийн болон ургамлын харилцан үйлчлэлд мониторинг хийж үнэлэх.  Усыг ашиглаж эхэлснээс хойш 12 сарын дотор дараах судалгааг хийх шаардлагатай.  а) Урт үндэстэй олон наст ургамал болон усны нөөц газрын хөрсний чийг хоорондын харилцан уялдаа, ялангуяа гол болон шал тойрмын хурдас, бусад бага гүний усны давхаргын системүүд, тэдгээр системээр тэжээгддэг ургамлуудыг харилцааг уялдааг тодорхойлох;	5 жилийн турш жил бүр хийж цаашид давтамжийг өөрчлөх эсэхийг шалгах	Гүний хоолой

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
		b) Төрөл бүрийн чийглэг бүхийн хөрсөн доорх ургамлын усны тэнцвэрийн мониторинг ба хөрсний чийглэгт үзүүлэх хариу үйлдэл  c) Бүсийн уст давхаргын түвшин буурахтай холбоотойгоор хөрсний чийгээр тэжээгддэг ургамалд болзошгүй өөрчлөлт гарах болон тэдгээр өөрчлөлтөд ургамлын үзүүлэх болзошгүй хариу  d) Усны нөөцийн хэмжээнд Монгол улсын Биологийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн боловсруулсанчлан ургамлын нөхцөл, олон янз байдал болон биомасст хийх тогтмол мониторинг		
Гүний усны нөөцийн БОНБНУ	Амьтанд үзүүлэх нөлөөлөл	Гадаргын усны гүн болон хамрах талбайн хэмжээнд мониторинг хийх		Ундай гол, Саглагарын сайр, Бутын нуур, Булан сухайт, Сэвхүүл ус, Булаг баянгийн задгай, Амтгайн тойром, Баянгийн тойром ба Ухаа загийн гол
Гүний усны нөөцийн БОНБНУ	Амьтанд үзүүлэх нөлөөлөл	Төрөл зүйлийн популяци, олон янз байдал болон экологийн талаар өргөн хүрээний ойлголттой болохын тулд шинжлэх ухааны хүрээлэн ба засгийн газрын агентлагуудтай хамтран ан амьтны урт хугацааны бүсчилсэн мониторингийн хөтөлбөрийг боловсруулах.	Төслийн хэрэгжилтийн бүхий л хугацааны турш хэрэгжүүлэх	
Гүний усны нөөцийн БОНБНУ	Ургамал	25 м <sup>2</sup> талбайнуудад дахь нягтшил, тархац ба нөхцөлд мониторинг хийх.	Жил бүр 7 сард.	Ундай голын адагийн баруун болон зүүн дэнж, Булан сухайт, Дайчингийн заг ба Галбын говийн Хонгор овоо,

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
				Алаг баяны төв хөндий, Амтгайн баруун хөндий, Гүний хоолойн Бор овооны тал
Гүний усны нөөцийн БОНБНУ	Ургамал	<p>Дараах мониторинг хийх:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ундайн голын хайлаас моднууд (Алаг баян, Арцавчирын булгуудын орчим)</li> <li>• Дайчингийн заган төгөл (Гүний хоолойн төв хөндийн 4 цэг ба Гүний хоолой/Амтгайн тойромын баруун хэсгийн зүүн хэсэг дэх 4 цэг);</li> <li>• Булансухайн сухай мод (Хэмгийн худгийн орчим).</li> </ul>	Жил бүр	Ундай гол Дайчингийн Булансухай
Ундай голын урсацад тохируулгах хийх төслийн БОНБНУ	Ургамал	Оюу Толгойн Байгаль Орчны хэлтэс Ундай голын урсацад тохируулга хийсэн хэсгээс цаашаа сайрын дагууд ургамалжилт, фенологийн мониторинг хийнэ. Үүнд зүйлийн бүрдэл, тусгаг бүрхэц, ярус, өсөлт хөгжилт зэрэг үзүүлэлтийг хянах бөгөөд төслийн нөлөөллийн бүсэд байх бусад цэгүүдийн дүн мэдээтэй харьцуулж дүн шинжилгээ хийнэ	Сар бүр	Нөхөн сэргээсэн талбайд
Ундай голын урсацад тохируулгах хийх төслийн БОНБНУ	Амьтан	Оюу Толгойн Байгаль Орчны хэлтэс амьтдын зүйлийн бүрдэл, амьдрах орчин, тоо толгойд ажиглалт хийж байгаль орчны суурь судалгааны мэдээ тайлангуудын үр дүнтэй харьцуулалт хийнэ	Нөхөн сэргээлт дууссанаас хойш 5 жилийн туршид улирал тутамд	Нөхөн сэргээсэн талбайд

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

<b>Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ	Ургамал	Ургамлын төрөл зүйл, бүрхүүл (%), төрөл зүйлийн тоо, бодгалийн хэмжээ, ургамлын дундаж өндөр (см), 25 м x 25 м хэмжээтэй мониторингийн талбайд байгаа малын тэжээлийн ургамлын биомасс (кг/га) зэрэгт мониторинг хийж, Ботаникийн хүрээлэнгийн 1992 онд хийсэн суурь судалгаатай харьцуулах.	Жил бүрт 7/8 сард	<ol style="list-style-type: none"> <li>1. Барилгын кемпийн урд талд 648165/4467018 солбицолд</li> <li>2. Хьюго Нортын зүүн талын 654014/4768002 солбицолд</li> <li>3. Хьюго Нортын зүүн-өмнөд талын 653602/4767396 солбицолд</li> <li>4. Хаягдал ус зайлуулах талбайн зүүн-өмнөд талын 655983/4758952 солбицолд</li> <li>5. Ундай голын баруун өмнөд талын 647500/4759625 солбицолд</li> <li>6. Хэрсийн худгийн ойролцоо 647415/4767468 солбицолд</li> </ol>
Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ	Дахин ургамалжуулалт	Хаягдал чулуулгийн овоолго, хаягдлын далан болон зам барилгын дараа нөхөн сэргээгдсэн газар гэх мэт эвдэрсэн газруудын ургамлыг дахин сэргээсэн байдалд мониторинг хийх.	Жил бүр	
Уурхайн олборлолт ба	Амьтан	Орон нутгийн нүүдлийн амьтдын төрөл зүйлүүдэд мониторинг хийх	Эхний 5 жилд жил бүр мониторинг	Улаантолгой болон Хөх хадны булгууд, Мааньтын

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

ID	Сэдэв/Чиглэл	Аргачлал	Давтамж	Байршил
баяжуулалтын БОНБНУ			хийж, дараа нь хянах	(Бурхант) худаг ба Том гэр
Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ	Амьтан	Хэвлээр явагч болон мэрэгч амьтдад Биологийн хүрээлэнгийн (1992 он) хээрийн бичиглэлд зориулж хийсэн анкетын дагуу мониторинг хийх.	Эхний 5 жилд жил бүр мониторинг хийж, дараа нь хянах	Төслийн талбай, Дугатын худгийн орчинд
Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ	Сээр нуруугүй амьтад	Биологийн хүрээлэнгийн (1992 он) хээрийн бичиглэлд зориулж хийсэн анкетын дагуу мониторинг хийж, ажиглалтыг бүртгэх.	Эхний 5 жилд жил бүр мониторинг хийж, дараа нь хянах	Төслийн талбайн хэмжээнд
Уурхайн олборлолт ба баяжуулалтын БОНБНУ	Шувуу	Биологийн хүрээлэнгийн (1992 он) хээрийн бичиглэлд зориулж хийсэн анкетын дагуу мониторинг хийж, ажиглалтыг бүртгэх.	Эхний 5 жилд жил бүр мониторинг хийж, дараа нь хянах	Төслийн талбайн болон бүсийн хэмжээнд



Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1

## 8. СУРГАЛТ

### 8.1. Тойм

Биологийн олон янз байдлын удирдлагын энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтыг талбайн ерөнхий болон зочдын сургалт, жолоочийн сургалт ба цахилгаан дамжуулах шугамын үзлэг, замын үзлэг ба засвар үйлчилгээ, тээврийн хэрэгсэл ба агаарын хөлөгт аюулгүй байдлын ажилтан үзлэг хийх тухай гэх мэт ажил үүрэгт хамааралтай сургалтуудад оруулсан.

### 8.2. Танилцуулга болон давтан сургалт

Биологийн олон янз байдлын тухай мэдлэг олгох сургалтыг дараах сургалтуудад оруулсан:

- Зочдод зориулсан зааварчилгаа;
- Оюу Толгойн ажилчид, гэрээт гүйцэтгэгч нарт зориулсан талбайн ерөнхий зааварчилгаа;
- Оюу Толгой ажилчид, гэрээт гүйцэтгэгч нарт зориулсан шинэ ажилчдад мэдлэг олгох багц сургалт.

Оюу Толгойн зэрлэг ургамал, амьтан, тэдгээрийн хууль бус бүтээгдэхүүний тухай бодлого (ОТ-10-Е9-PLC-1001) нь Оюу Толгойн ажилчид, гэрээт гүйцэтгэгч нарт зориулсан сургалтын багцад орсон.

### 8.3. Ажлын байран дах сургалт

Оюу Толгой болон гэрээт жолооч нарт хамааралтай Биологийн олон янз байдлын удирдлагын шаардлагуудыг Оюу Толгойн талбайн замын хөдөлгөөний удирдлагын өргөн хүрээний төлөвлөгөө (ОТ-10-С3-STD-0003-Е-С3), Хөнгөн тэрэг жолоодох журам (ОТ-10-С3 – PRC-0003-Е) болон Хүнд даацын тээврийн хэрэгсэл жолоодох журмын (ОТ-10-С3-PRC-0002-Е) заавал биелүүлэх шаардлагуудад тусгасан.

Цахилгаан дамжуулах шугамд мөргүүлсэн шувууны сэг зэм байгаа эсэхийг шалгах болон үүрийг зайлуулахын тулд ажиглалт үзлэг хийх, тэдгээр үзлэгийн мэдээллийг харьцуулж, тайлагнахад тухайн ажлын онцлогод тохирсон нэмэлт сургалтууд шаардлагатай. Цахилгаан дамжуулах шугамын дагуу үзлэг шалгалт хийх журмыг боловсруулах болно.

Газрын нөхөн сэргээлтийг Оюу Толгойн ажилчид ба гэрээт гүйцэтгэгч нар газар ашиглалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, уурхайн хаалтын төлөвлөгөө (ОТ-10-Е9-PLN-0002) болон газрын нөхөн сэргээлт (ОТ-10-Е9-PRC-0002), шимт хөрсний удирдлагын журмуудын (ОТ-10-Е9-PRC-0001) заавал биелүүлэх шаардлагуудын дагуу хэрэгжүүлэх болно.

Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд газар хөндөх зөвшөөрлийг газар хөндөх зөвшөөрлийн журмын (ОТ-10-Е9-PRC-0003) дагуу ашиглахын тулд тухайн ажлын онцлогод тохирсон сургалтанд хамрагдах болно.

Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-E9-PLN-0003-M	Хувилбар: 1.1

## 9. АУДИТ БА ТАЙЛАН

### 9.1. Дотоод аудит

Төслийн үйл ажиллагааны хэсгийн ахлах ажилтнууд нь эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны өргөн хүрээтэй асуудлуудыг хамруулан өдөр тутмын үзлэг шалгалт хийнэ. Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны хэлтэс тогтмол нэмэлт үзлэг шалгалтыг бэлтгэсэн шалгах жагсаалтын дагуу гүйцэтгэнэ. Шалгалтын явцад илэрсэн зөрчлийг удирдлагын системд бүртгэнэ (14-р хэсэг).

Тус төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэхийг дотоод аудит болон жил бүрийн үзлэг шалгалтаар тодруулах болно. Шалгалтыг хийхдээ эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын системийн шаардлагуудтай хэрхэн нийцэж байгааг өргөн хүрээнд авч үзнэ (Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон бусад удирдлагын төлөвлөгөөнүүдийг мөн хамруулна).

**Дээрх шалгалтын явцад илэрсэн бүх осол зөрчлийг Оюу Толгойн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны удирдлагын системийн шаардлагад заасны дагуу бүртгэн мэдээлнэ.**

### 9.2. Гадаад аудит

Рио Тинто компаний аудит болон төслийн зээлдүүлэгч нарын аудит болон баталгаажуулалтын хөтөлбөрүүдийн хүрээнд тус төлөвлөгөөнд нийцэн ажиллаж байгаа эсэхэд үе үе үнэлгээ хийх болно.

### 9.3. Бүртгэл хөтлөлт

Аудит, үзлэг шалгалт болон осол зөрчлийн тайлан мэдээллүүдийг бичиг баримтын бүртгэл хөтлөх журам (8-р хэсэг), мэдээ тайлангийн удирдлагын (15-р хэсэг) дагуу бүртгэн хөтлөнө.

Дотоод болон хөндлөнгийн аудитийн дүгнэлт, холбогдох арга хэмжээ, осол зөрчил болон түүнтэй холбогдох арга хэмжээг Рио Тинтогийн бизнес шийдлийн системийг ашиглан бүртгэнэ.

## ОЮУ ТОЛГОЙ ХХК

### Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е9-PLN-0003-М	Хувилбар: 1.1
--	---	------------------

#### 10. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Файлын нэр	ОТ-10-Е9-PLN-0003-М- Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө
Тодорхойлолт	Биологийн олон янз байдлын удирдлагын төлөвлөгөө
Эхийг зохиогч	Биологийн олон янз байдлын баг
Үүсгэсэн огноо	2013.09.01
Баталсан албан тушаалтан	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийг бүртгэх дугаар	#

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Үнэлгээ хийсэн албан тушаалтан	Хянах хугацаа	Дараагийн хянах огноо
Өндөр	2013.09.01	Биологийн олон янз байдлын баг	Жил бүр	2014.09.01

Хувилбар	Хянан засварласан огноо	Зохиогч	Баталсан	Хянан засварласан тэмдэглэл
1.0	2013.09.01	Биологийн олон янз байдлын баг	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баталсан.
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	Марк Слэйтер, ЭМААБО хэлтэсийн Ерөнхий менежер	Баримт бичгийн дугаарлалтыг засч, баримт бичгийг хянав.